



2026 оны 03 дугаар сарын 11-ны өдөр

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, практик шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын иргэний нисэхийн эрх зүйн тогтолцоо нь олон улсын иргэний нисэхийн гэрээ, конвенц болон тэдгээрт нийцүүлэн гаргасан үндэсний хууль тогтоомж, дүрэм, журмаас бүрддэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан.

Монгол Улс 1989 онд Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцод нэгдэн орсноор Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн, хэлэлцэн тохиролцогч улс болж, тус байгууллагын стандарт, зөвлөмж, шаардлагыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн.

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд бүрэн хэмжээний аудит шалгалтыг Монгол Улсад 2026 оны 4 дүгээр сард хийхээр тогтсон.

Аудит шалгалтыг хууль эрх зүйн орчин, иргэний нисэхийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, агаарын навигацийн, нислэгийн, аэродромын үйл ажиллагаа, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт, осол зөрчлийг шинжлэн шалгах, үнэмлэх, гэрчилгээжүүлэлт гэсэн 8 чиглэлээр хийж, олон улсын стандарт, зөвлөмж, дүрэм, журмын хэрэгжилт, түүнд тавьж буй төрийн хяналтын хүрээнд хянан дүгнэх бөгөөд үнэлгээ нь манай улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын түвшинг дэлхийд илэрхийлэх үндсэн шалгуур болох юм.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас дээрх аудит шалгалтын урьдчилсан шатны үзлэг, шалгалтыг 2025 оны 9 дүгээр сард хийж, Монгол Улс энэхүү шалгалтад бэлэн биш, хангалтгүй үнэлгээ авахаар байгаа талаар анхааруулж, одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Иргэний нисэхийн тухай хуульд конвенцын зохицуулалтуудыг бүрэн тусгах, түүний хавсралтаар тогтоосон стандартад нийцүүлэх шаардлагатайг зөвлөсөн.

Дээр дурдсан үндэслэлүүд нь Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага:

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийсэн урьдчилсан шатны үзлэг, шалгалтаар салбарын эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэхийн зэрэгцээ иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын оновчтой, бие даасан, хараат бус санхүүгийн чадавх бүхий тогтолцоог бүрдүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлдэх, сургах, дадлагажуулах шаардлагатайг зөвлөж, одоо дүгнэгдэж байгаачлан бага үнэлгээ авах, эсхүл ноцтой аюулгүй байдлын асуудалтай гэж тодорхойлогдвол Монгол Улсын агаарын тээврийн салбар өндөр хэмжээний алдагдалд орж, буцааж нөхөхөд 10 хүртэлх жилийн хугацаа зарцуулахыг анхааруулсан.

Дээрх урьдчилсан үзлэг, шалгалтаар өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон дараах чиглэлүүд байна. Үүнд:

- Иргэний нисэхийн тухай хуульд гишүүн орны иргэний нисэхийн харилцааг зохицуулсан үндсэн зохицуулалт зохих ёсоор тусгагдаагүй, конвенцын шаардлагад нийцээгүй, зөрчилтэй. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байх эрх зүйн статусыг хуулиар тогтоож, баталгааг хангах;
- Салбарын сайд нь СЕ-2 түвшний буюу иргэний нисэхийн дүрмүүдийг баталж, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь СЕ-5 түвшний хяналт шалгалтын заавар, журмыг баталж байгаа нь Иргэний нисэхийн ерөнхий газрын бие даасан байх конвенцын шаардлагатай зөрчилдөж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бүх стандарт, зөвлөмжийн нэмэлт өөрчлөлтүүдийг цаг хугацаанд нь иргэний нисэхийн дүрэмд тусгахад сөргөөр нөлөөлж байгаа нь Монгол Улсын нийцэлд ноцтой эрсдэл үүсгэж байна.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын тасралтгүй, тогтвортой байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр, түүний зохион байгуулалт, нисэхийн аюулгүй байдлын хяналтыг үр дүнтэй явуулахад шаардагдах зохих мэргэшсэн, туршлагатай боловсон хүчнийг бүрдүүлэхэд санхүүгийн болон бусад нөөц хангалттай байх нөхцөлийг салбарын хуульд тусгах;
- Хяналт, шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэх иргэний нисэхийн хяналтын байцаагчид нь зохих, шаардлагатай сургалтад бүрэн хамрагдсан байх;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт (СЕ-2) болон техникийн гарын авлага, заавар, журам, туслах хэрэгслүүд (СЕ-5)-ийн хүрээнд иргэний нисэхийн дүрэм, журам, аэродромын

төлөвлөлтийн шаардлага, үйл ажиллагаа болон нисдэг тэрэгний талбайтай холбоотой журам, зохицуулалтыг цаг хугацаанд нь батлах, шинэчлэх бүрэн эрхтэй байхаар хуульд тусгах;

- Эрх шилжүүлэх тогтолцоог уялдаатай, тодорхой болгох, мөн дүрмийн шаардлагаас чөлөөлөх зохицуулалтыг нэмж тусгах;
- Чикагогийн конвенц болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт шаардлагуудын дагуу агаарын хөлөгт авч явах баримт бичиг, нислэгийн бүртгэлийн дэвтэр, аюултай барааны зохицуулалтыг тусгах;
- Нислэгт тэнцэх чадварын дүрэм нь конвенцын Хавсралт 6, 7, 8, 16-д орсон сүүлийн өөрчлөлттэй нийцсэн байх ёстой тул Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь тодорхой үйл ажиллагааны дүрэм, бусад дагаж мөрдөх журам, заавар, мэдэгдлийг цаг алдалгүй батлах, эсвэл шинэчлэх эрхтэй байхаар тусгах;
- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь гэрч болон шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдол өгөх бусад хүмүүстэй ярилцлага хийх (Протокол асуулт 6.027), Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны тэмдэглэлийн хамгаалалтыг хангах (Протокол асуулт 6.031), Бүхээгийн ярианы бичлэг болон агаарын хөлгийн нислэгийн үеийн өгөгдөл дүрс бичлэгийг нууцлах, задруулахгүй байхыг баталгаажуулах (Протокол асуулт 6.029) зохицуулалт тусгах;
- Чикагогийн конвенцын 1 дүгээр зүйл “Бүрэн эрхт байдал”, 2 дугаар зүйл “Нутаг дэвсгэр”, 12 дугаар зүйл “Нислэгийн дүрэм”, 25 дугаар зүйл “Аюул тулгарсан агаарын хөлөг”-ийн хүрээнд аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх талаар, 3 bis зүйлийн хүрээнд агаарын хөлгийн аюулгүй байдал, зорчигчдын амь насанд аюул учруулахгүй байх талаар тус тус тодорхой зохицуулалт тусгах;
- Монгол Улсын хуулийн нэр томъёоны тодорхойлолтод заасан нэр томъёог Чикагогийн Конвенц болон түүний хавсралтад заасан нэр томъёотой нийцүүлэх, нислэгийн зургийн үйлчилгээ, хүрээлэн буй орчинд нөлөөлөх иргэний нисэхийн нөлөөллийн талаар заалт оруулах;
- Албадлагын арга хэмжээний талаарх зохицуулалтыг Иргэний нисэхийн тухай хуульд тодорхой тусгах;
- Иргэний нисэхийн тухай хуульд Иргэний нисэхийн ерөнхий газар нь боловсон хүчний үнэмлэх, агаарын операторын гэрчилгээ, бүртгэлийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, агаарын хөлгийн радио станцын лиценз, аэродромын гэрчилгээ болон агаарын хөлгийн радио станцын лиценз олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй байхаар тусгах;
- Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь хяналт, шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх, нисэхийн баримт бичигтэй танилцаж, шалгах боломжийг хуульчлах;

- Иргэний нисэхийн тухай хуульд Чикагогийн конвенцын 83 bis зүйлд заасан чиг үүрэг, эрх шилжүүлэх зохицуулалт болон навигацийн үйлчилгээ үзүүлж буй агаарын хөлөг бүрд аяллын бүртгэлийн дэвтэр хөтлөх ёстой талаар зохицуулалтыг нарийвчлан тодорхой тусгах, зэрэг болно.

Мөн Үндэсний аудитын газраас 2025 онд “Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө”-нд гүйцэтгэлийн аудит хийж, төрийн бодлого, тогтолцооны алдаанаас иргэний нисэхийн салбар мэргэшсэн хүний нөөцийн дутагдал, техник, технологийн хоцрогдолд орж, олон улсын өмнө хүлээсэн аюулгүй байдлыг хангах үүрэг алдагдах эрсдэлтэй байгаа талаар дараах дүгнэлт гаргасан. Үүнд:

- Олон улсын гэрээний дагуу үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, салбарын бодлого, эрх зүйн зохицуулалт, хууль хоорондын нийцэл алдагдсан;
- Иргэний нисэхийн салбарын өнөөгийн эрх зүй, удирдлага, санхүүжилтийн тогтолцооны доголдлыг арилгаагүй тохиолдолд салбарын аюулгүй байдал, олон улсын нэр хүнд, эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх эерэг нөлөө буурах;
- Агаарын навигацийн үйлчилгээ үзүүлсний хураамжийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа нь салбарын аюулгүй байдал, хяналтын тогтолцоог хангах Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй нөхцөлд хүргэж байна;
- Иргэний нисэхийн ерөнхий газар нь нэг талаас Засгийн газрын агентлаг буюу төрийн захиргааны байгууллага, нөгөө талаас ТӨААТҮГ гэсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, 2 өөр хариуцлагын хэлбэрийг нэг байгууллага хэрэгжүүлснээр эрх олгох, хянах чиг үүрэг, бодлогын хэрэгжилт, салбарын бодлого зохицуулалт, хяналтын чиг үүргийг давхар хэрэгжүүлж, санхүүгийн зохистой удирдлагыг хангахад хүндрэл учруулсан;
- Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад гэрчилгээ олгох, байнгын хяналт, шалгалт явуулах мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэшсэн байцаагч, мэргэжилтний нөөц дутагдалтай нь салбарын хяналтын үр нөлөө, аюулгүй ажиллагааны үнэлгээний чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн;
- Иргэний нисэхийн ерөнхий газар нь төрийн захиргааны байгууллагад хамаарч, ажилтан, албан хаагчид нь төрийн жинхэнэ албан хаагч байхаар байна. Гэтэл конвенцын хавсралт 19 “Аюулгүй байдлын удирдлага” болон Doc.10070 “Иргэний нисэхийн аюулгүй байдлын байцаагчийн чадамжийн гарын авлага”-д иргэний нисэхийн байцаагчийн мэдлэг, ур чадвар, чадамж, байцаагчийг ажиллуулах орчин нөхцөл, сургалтын үе шат, чадавхжуулах тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг нарийвчлан заасан, энэ 2 шаардлага хоорондоо зөрчилдөж байна, зэрэг болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын хүрээнд Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, конвенцын шаардлагад нийцүүлэн дараах зохицуулалтыг хуульчилна. Үүнд:

- Иргэний нисэхийн тухай хуулийн нэр томьёо;
- Салбарын сайд болон Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын бүрэн эрх, чиг үүрэг;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангах, санхүүгийн эх үүсвэр, агаарын навигацийн хураамжийн тодорхой хувийг зориулалтын дагуу зарцуулах асуудал;
- Иргэний нисэхийн байцаагч болон мэргэжилтнүүдэд тавигдаж буй конвенцын хавсралтын шаардлага;
- Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгох үйл ажиллагаа;
- Иргэний нисэхийн дүрмүүдтэй холбогдох хуулийн зохицуулалт;
- Агаарын хөлгийн бүрдэл хэсэг, агаарын хөлөгт авч явах баримт бичиг, хүрээлэн буй орчны хамгаалалт, агаарын тээвэрлэгчийн болон агаарын хөлгийн даргын үүрэг;
- Аюул тулгарсан агаарын хөлгийн зохицуулалт, нисэхийн цаг уурын үйлчилгээ, аэродромын аюулгүйн бүс;
- Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх, түүний ажиллах нөхцөл, баталгаа;
- Иргэний нисэхийн баримт бичиг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалт;
- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын үйл ажиллагааг конвенцын шаардлагад нийцүүлэн хуульд тусгах.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна. Үүнд:

- Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бүрэн хэмжээний аудит шалгалтад амжилттай хамрагдах, ингэснээр улс орны хөгжлийн стратегийн чухал тулгуур болсон иргэний нисэхийн салбарын үйл ажиллагааг хөгжүүлэх, улмаар аялал жуулчлал, гадаад худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагаа өргөжих;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал хангагдах, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлж, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Иргэний нисэхийн салбарын мэргэшсэн хүний нөөцийн дутагдал арилах, агаарын навигацийн үйлчилгээний инженерийн дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтыг сайжруулах боломж бүрдэх, зэрэг олон талын эерэг нөлөө үзүүлнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц, түүний хавсралтууд, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, дотоодын холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---oOo---

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл: Иргэний нисэхийн тухай хуульд нэмэх зүйл, хэсэг, заалт

- 1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг
- 2/5 дугаар зүйлийн 5.1.21-5.1.24 дэх заалт
- 3/7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт
- 4/9 дүгээр зүйлийн 9.2.6-9.2.9 дэх заалт
- 5/9 дүгээр зүйлийн 9.4-9.6 дахь хэсэг
- 6/10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалт
- 7/10 дугаар зүйлийн 10.2.11-10.2.12 дахь заалт
- 8/12 дугаар зүйлийн 12.1.21 дэх заалт
- 9/12 дугаар зүйлийн 12.2-12.4 дэх хэсэг
- 10/14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэг
- 11/15¹ дүгээр зүйл
- 12/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг
- 13/19¹ дүгээр зүйл
- 14/21 дүгээр зүйлийн 21.6, 21.7 дахь хэсэг
- 15/21¹ дүгээр зүйл
- 16/24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг
- 17/25 дугаар зүйлийн 25.4-25.5 дахь хэсэг
- 18/27¹ дүгээр зүйл
- 19/32 дугаар зүйлийн 32.3-32.5 дахь хэсэг
- 20/37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг
- 21/39¹ дүгээр зүйл
- 22/44 дүгээр зүйлийн 44.2.3 дахь заалт

2 дугаар зүйл: Иргэний нисэхийн тухай хуулийн хэсэг, заалтын нэмэлт

3 дугаар зүйл: Иргэний нисэхийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалтын өөрчилсөн найруулга

- 1/5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт
- 2/8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт
- 3/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг
- 4/11 дүгээр зүйл
- 5/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг
- 6/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг
- 7/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг
- 8/38 дугаар зүйл
- 9/39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг

4 дүгээр зүйл: Иргэний нисэхийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалтад оруулах үгийн өөрчлөлт

5 дугаар зүйл: Иргэний нисэхийн тухай хуулийн хэсгээс зарим үг хасах

6 дугаар зүйл: Хуулийг дагаж мөрдөх хугацаа

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2. Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийн агаарын орон зайд төгс¹, онцгой бүрэн эрхтэй.”

2/5 дугаар зүйлийн 5.1.21-5.1.24 дэх заалт:

“5.1.21. “зорчигч” гэж арилжааны нислэгийн хувьд тээвэрлэлтийн гэрээний дагуу агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг, арилжааны бус нислэгийн хувьд агаарын хөлөгт зорчиж байгаа нисгэгчээс бусад этгээдийг;

5.1.22. “нисэхийн баримт бичиг” гэж аливаа этгээд, агаарын хөлөг, аэродром, нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нислэгийн журам, нисэхийн холбоотой үйлчилгээнд энэ хууль, иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, зөвшөөрөл, эсхүл бусад баримт бичгийг;

5.1.23. “ноцтой зөрчил” гэж осол гарах өндөр магадлалтай нөхцөл үүссэн бөгөөд хүнтэй агаарын хөлгийн хувьд, нислэг үйлдэх зорилгоор аливаа этгээд агаарын хөлөгт орсон цагаас эхлээд тухайн этгээд буух цаг хугацааны хооронд, эсхүл хүнгүй агаарын хөлгийн хувьд, нислэг үйлдэх зорилгоор агаарын хөлөг хөдлөхөд бэлэн болсон цагаас эхлээд нислэгийн төгсгөлд зогсож, үндсэн хөдөлгүүрээ унтраах хүртэлх хугацааны хооронд агаарын хөлгийн ашиглалттай холбоотой гарсан тохиолдлыг;

5.1.24. “улсын нутаг дэвсгэр” гэж тухайн улсын бүрэн эрхт байдал, ивээл, хамгаалалтад байгаа, эсхүл эрхээ хэрэгжүүлж байгаа хуурай газар болон нутгийн усыг.”

3/7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалт:

“7.1.6. иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангахуйц төсөв санхүү, хүний нөөц, цалин хөлсний хэмжээг Конвенцод нийцүүлж батлах;”

4/9 дүгээр зүйлийн 9.2.6-9.2.9 дэх заалт:

¹ Төрийн мэдээлэлд хэвлэгдсэн Чикагогийн конвенцод багтаасан.

“9.2.6.олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын, болон агаарын тээврийг хялбаршуулах журмыг боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.7.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын эрсдэлд суурилсан хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх;

9.2.8.хууль, дүрэм, журам, зааврыг дагаж мөрдүүлэх, хэрэгжүүлэх зорилгоор хүн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

9.2.9.иргэний нисэхийн салбарт сайн дурын болон заавал авах аюулгүй байдлын мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах.”

5/9 дүгээр зүйлийн 9.4-9.6 дахь хэсэг:

“9.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөртэй байна.

9.5.Иргэний нисэхийн ерөнхий газрын хяналтын байцаагч, ажилтныг тусгайлан бэлтгэх, сонгон шалгаруулах, чадавхжуулах, томилох, чөлөөлөхөд Төрийн албаны тухай хууль хамаарахгүй.

9.6.Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаа нь дараах эх үүсвэрээс санхүүжнэ:

9.6.1.агаарын навигацийн үйлчилгээний нийт хураамжийн 15-аас доошгүй хувийг;

9.6.2.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээнээс төвлөрүүлсэн орлого;

9.6.3.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

9.6.4.иргэний нисэхийн ерөнхий газрын чадамжийг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын санхүүжилт.”

6/10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалт:

“10.2.2.энэ хуулийн 37.2-т заасан шаардлагыг хангасан иргэний нисэхийн хяналтын байцаагчийг томилох, чөлөөлөх, эрх олгох, цуцлах;”

7/10 дугаар зүйлийн 10.2.11-10.2.12 дахь заалт:

“10.2.11.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох;

10.2.12.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай санхүү, захиргааны шийдвэр гаргаж, нэгдсэн удирдлагаар хангах;”

8/12 дугаар зүйлийн 12.1.21 дэх заалт:

“12.1.21.нисэхийн хангамжийн байгууллагыг гэрчилгээжүүлэх, агаарын хөлгийн түрээсийн зохицуулалт болон шалгалтын нислэгийн үйл ажиллагаа;”

9/12 дугаар зүйлийн 12.2-12.4 дэх хэсэг:

“12.2.Иргэний нисэхийн дүрэмд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинээр дүрэм гаргана:

12.2.1.Конвенцын хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүр боломжит хугацаанд;

12.2.2.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай нь тогтоогдсон;

12.2.3.иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэлт зохицуулалт хийх зайлшгүй нөхцөл үүссэн.

12.3.Иргэний нисэхийн дүрмийг шинэчлэн батлах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн дүрмийн дагуу эрх, үүрэг үүссэн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгаж болно.

12.4.Нислэгийн аюулгүй байдалд хамаарах онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шуурхай дүрэм, шилжилтийн цаг үеийн асуудлыг зохицуулах зорилгоор тусгай дүрэм гаргаж болно.”

10/14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэг:

“14.6.Нислэгт тэнцэх чадварын стандарт гэрчилгээтэйгээр ашиглах агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэхээс өмнө Дарга тухайн агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрсөн байна.

14.7.Иргэний агаарын хөлгийг ашиглалтаас хассан, эсхүл гадаад улсад бүртгүүлэх тохиолдолд Монгол Улсын бүртгэлээс хасна.”

11/15¹ дүгээр зүйл:

“15¹ дүгээр зүйл.Хүрээлэн буй орчны хамгаалалт

15¹.1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын 16 дугаар хавсралтад заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.

15¹.2.Энэ хуулийн 15¹.1-т заасныг хангасан агаарын хөлгийн хөдөлгүүрийн дуу чимээний гэрчилгээг Дарга олгоно.”

12/18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг:

“18.4.Гадаадын агаарын тээвэрлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт орон нутгийн тогтмол нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.”

13/19¹ дүгээр зүйл:

“19¹ дүгээр.Аюултай бараа тээвэрлэх

“19¹.1.Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болзошгүй аюултай барааг агаарын хөлгөөр тээвэрлэх, тээвэрлэлтэд бэлтгэж хүлээлгэн өгөх үйл ажиллагааг Иргэний нисэхийн дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн этгээдээр гүйцэтгүүлнэ.

19¹.2.Иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд агаараар тээвэрлэхийг хориглосон аюултай барааг тээвэрлэхийг санал болгох, эсхүл тээвэрлэлтэд хүлээн авахыг хориглоно.”

14/21 дүгээр зүйлийн 21.6, 21.7 дахь хэсэг:

“21.6.Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд агаарын хөлгийн дарга тухайн улсын эрх бүхий байгууллагаас холбоогоор болон саатуулагч агаарын хөлгөөс анхааруулга, эсхүл бусад дохиогоор өгсөн шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтлөсөн байна.”

15/21¹ дүгээр зүйл:

“21¹ дүгээр зүйл.Агаарын хөлөгт авч явах баримт бичиг

21¹.1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно:

21¹.1.1.агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

21¹.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөл;

21¹.1.3.хэрэв радио төхөөрөмжөөр тоноглогдсон бол агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;

21¹.1.4.багийн гишүүн бүрийн холбогдох хүчинтэй үнэмлэх;

21¹.1.5.нислэгийн бүртгэлийн дэвтэр, эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт;

21¹.1.6.хэрэв зорчигч тээвэрлэж яваа бол тэдний нэрийн жагсаалт, суусан болон очих газар;

21¹.1.7.хэрэв ачаа тээвэрлэж яваа бол тусгай ачааллын мэдээлэл агуулсан ачааны манифест;

21¹.1.8.иргэний нисэхийн дүрмээр шаардсан бусад баримт бичиг.

16/24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг:

“24.3.Үндэсний аюулгүй байдалд онц ноцтой хохирол учруулах эрсдэл үүссэн бөгөөд тухайн нөхцөлийг өөр аргаар зайлуулах боломжгүйгээс бусад тохиолдолд зөрчил гаргасан иргэний агаарын хөлгийн эсрэг зэвсэг хэрэглэхийг хориглоно.”

17/25 дугаар зүйлийн 25.4-25.5 дахь хэсэг:

“25.4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь аюул тулгарсан агаарын хөлгийн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

25.5.Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын нисэхийн байгууллагатай хамтран гүйцэтгэж болно. Улсын нисэхийн тухай² хуулийн 4.1.2-т заасан аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх аливаа арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигчийн саналыг үндэслэн Засгийн газар гаргана.”

18/27¹ дүгээр зүйл:

“27¹ дүгээр зүйл.Нисэхийн цаг уурын үйлчилгээ

27¹.1.Нисэхийн цаг уурын үйлчилгээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн нэгж үзүүлнэ.

27¹.2.Нисэхийн цаг уурын үйлчилгээний техникийн баримт бичгийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Иргэний нисэхийн ерөнхий газар хамтран батална.”

19/32 дугаар зүйлийн 32.3-32.5 дахь хэсэг:

“32.3.Аэродром орчим баригдах барилга, байгууламж, суурилагдах объект нь аэродромын саадыг хязгаарлах гадаргууг нэвтлэхээргүй, мөн аэродромын аюулгүйн бүсэд шувуу цугларах, татах нөхцөл үүсгэхээргүй байна.

32.4.Аэродром орчмын саадыг хязгаарлах гадаргуу болон аэродромын аюулгүйн бүсийн газар ашиглалтын хяналтыг аэродромын гэрчилгээ эзэмшигч тогтмол гүйцэтгэх бөгөөд энэ хуулийн 32.3-т заасныг зөрчсөн гэж Иргэний нисэхийн ерөнхий газраас тогтоосон тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн барилга, байгууламж, талбай, объектыг буулгах арга хэмжээг авна.

32.5.Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродром орчмын зэрлэг амьтан, шувууны аюулын судалгааг 3 жил тутам хийх ба тогтоогдсон эрсдэлийг арилгана.”

20/37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг:

“37.4.Хяналтын байцаагч нь хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ үнэнчээр гүйцэтгэн, иргэн, хуулийн этгээдийн хууль

² Улсын нисэхийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийх үүрэгтэй.”

21/39¹ дүгээр зүйл:

“39¹ дүгээр зүйл.Иргэний нисэхийн баримт бичиг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

39¹.1.Иргэний нисэхийн баримт бичиг эзэмших хүсэлт гаргах, түүнийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хураах харилцааг энэ хуулийн 12.1-д заасан дүрмээр зохицуулна.

39¹.2.Дарга энэ хуулийн 36.2 болон 36.3-т заасан хяналтын чиглэлээр гэрчилгээ олгох, гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгахдаа хууль, дүрмээр тогтоосон шаардлагын хүрээнд баримт бичгийн болон газар дээрх үзлэг шалгалт хийж баталгаажуулснаар шийдвэрлэнэ. Нисэхийн баримт бичигт түүнийг эзэмшигчийн дагаж мөрдөх үйл ажиллагааны нөхцөл, хязгаарлалтыг тогтоож болно.

39¹.3.Дарга энэ хуулийн 36.2.1 дэх хэсэгт заасан нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх эзэмшигчийн мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэндийн байдал нь энэ хуулийн 12.1-д заасан дүрмийн шаардлага хангаж байгааг баталгаажуулснаар тухайн төрлийн үнэмлэх, тохирох зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгоно.

39¹.4.Дарга Конвенцын хэлэлцэн тохиролцогч улсаас олгосон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ болон бусад нисэхийн баримт бичгийг баталгаажуулан зөвшөөрч болно.

39¹.5.Хэлэлцэн тохиролцогч аливаа улсаас хувь хүнд олгосон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ нь Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм, Конвенцын хавсралтад заасан стандартад нийцээгүй тохиолдолд Дарга хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй.

39¹.6.Иргэний нисэхийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт орсны дараах дахин гэрчилгээжүүлэлт нь уг баримт бичгийг шинэчлэн батлагдсан өдрөөс нэг жилийн өмнөх хугацаанд олгосон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээнд хамаарахгүй бөгөөд тухайн баримт бичгийг олгогдсон хугацааны турш хүчин төгөлдөр хэвээр байна.”

22/44 дүгээр зүйлийн 44.2.3 дахь заалт:

“44.2.3.осол, зөрчилтэй холбоотой агаарын хөлгийн багийн гишүүд, зорчигч, гэрч болон бусад этгээдээс ярилцлага, мэдүүлэг авах;”

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтын “дүрмийг” гэсний дараа “Конвенцын 13 дугаар хавсралтад нийцүүлэн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтын “мэдээллийн санг хөтлөх” гэсний дараа “, хамгаалах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн санд тулгуурласан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “тээвэрлэгчийн” гэсний дараа “хариуцлагын” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “үзүүлэх” гэсний дараа “, шаардлагатай бол зорчигчийн мэдээллийг хууль

тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэх” гэж, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “ажиллагаа нь” гэсний дараа “Иргэний нисэхийн ерөнхий газар, шүүх шинжилгээ болон бусад байгууллагаас” гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “инженер,” гэсний дараа “нислэгийн хөдөлгөөний удирдагч” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2.1 дэх заалтын “зөрчилтэй холбоотой” гэсний дараа “газар болон” гэж, 45 дугаар зүйлийн 45.1.2 дахь хэсгийн “авах” гэсний дараа “, задруулахгүй байх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт:

“5.1.8.“зөрчил” гэж агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох ослоос бусад эрсдэл бүхий индицент буюу тохиолдлыг;

Тайлбар: Энэ хуулийн 24 дүгээр зүйлд зааснаас бусад энэ хуульд хэрэглэсэн “зөрчил” гэх нэр томъёог Конвенцын 13 дугаар хавсралтад заасан инцидент буюу тохиолдол гэж ойлгож хэрэглэнэ;”

2/8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт:

“8.1.9.иргэний нисэхийн ерөнхий газар, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын бүтцийг батлах;

Тайлбар:Энэ хуулийн “агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага” гэснийг Конвенцын 13 дугаар хавсралтад заасан агаарын хөлгийн осол, инцидентыг шинжлэх шалгах алба гэж ойлгож хэрэглэнэ.”

3/9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагын өмнө хариуцлага хүлээж хараат бус бие даасан байдлаар энэ хуулийн 9.6-д заасан орлогоор санхүүжин үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна.”

4/11 дүгээр зүйл:

“11 дүгээр зүйл.Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгох

11.1.Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгохтой холбоотой журмыг холбогдох олон улсын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэн Дарга батална.

11.2.Дарга иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт хийх эрхийг иргэний нисэхийн хяналтын байцаагчид энэ зүйлийн 11.1-т заасан журмын дагуу олгоно.

11.3.Дарга иргэний нисэхийн хяналтыг үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх зорилгоор энэ зүйлийн 11.1-т заасан журмын дагуу зохих шаардлага хангасан этгээдэд итгэмжлэл олгож болно.

11.4.Дарга энэ зүйлийн 11.2-т заасны дагуу эрх, 11.3-т заасны дагуу итгэмжлэл олгосон нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.5.Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг өөр улсад түрээсээр ашиглуулахад Дарга тухайн агаарын хөлгийг ашиглах агаарын тээвэрлэгчийн харьяалах улстай Конвенцын 83 bis дугаар зүйлийн дагуу Конвенцын 12, 30, 31 болон 32(а) зүйлд заасан үүрэг, хариуцлага шилжүүлэх гэрээ байгуулж болно.

11.6.Дарга энэ зүйлийн 11.5-д заасны дагуу гэрээ байгуулсан бол Иргэний нисэхийн олон улсын байгууллагад болон агаарын тээвэрлэгчид мэдээлнэ.

11.7.Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг энэ зүйлийн 11.5-д заасан гэрээ байгуулан Монгол Улсын агаарын тээвэрлэгч ашиглах тохиолдолд Дарга Конвенцын холбогдох зүйлд заасан тухайн агаарын хөлөгт хамаарах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.”

5/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлж, агаарын хөлгийн бүртгэл, өмчлөлтэй холбоотой мэдээллийг Конвенцын хэлэлцэн тохиролцогч улс, эсхүл Олон улсын иргэний нисэхийн байгууллагын хүсэлтээр гаргаж өгнө.”

6/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:

“21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална.”

7/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Онцгой байдлын байгууллага аюул тулгарсан агаарын хөлгийг эрэн хайх, нисэх баг, зорчигчдыг авран туслах үйл ажиллагааг иргэний нисэхийн эрэн хайх, аврах ажиллагааны бүсэд гүйцэтгэх бөгөөд энэ бүс нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон агаарын зайг хамарна.”

8/38 дугаар зүйл:

“38 дугаар зүйл.Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх

38.1.Хяналтын байцаагч нь дараах бүрэн эрхтэй:

38.1.1.хяналт шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой дараах объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх:

- 38.1.1.1.агаарын хөлөг;
- 38.1.1.2.аэродром, нисэх буудал;
- 38.1.1.3.агаарын навигацийн байгууламж;
- 38.1.1.4.ангар;
- 38.1.1.5.техникийн үйлчилгээний байгууллага;
- 38.1.1.6. засварын газар, цех;
- 38.1.1.7.түлш хадгалах байгууламж;
- 38.1.1.8.нисэх буудлын перрон;
- 38.1.1.9.нисэхийн сургалтын байгууллага;

38.1.1.10.агаарын тээвэрлэгч болон нисэхийн баримт бичиг эзэмшигчийн байр;

38.1.1.11.ачаа, шуудангийн байгууламж, талбай;

38.1.1.12.бусад хамаарал бүхий байгууламж;

38.1.2.хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор дараах нисэхийн баримт бичгийг шаардан гаргуулах, систем рүү нэвтрэх:

38.1.2.1.үйл ажиллагааны заавар, журам, зааварчилгаа;

38.1.2.2.техникийн баримт бичиг;

38.1.2.3.ажилтны хувийн хэрэг;

38.1.2.4.олгогдсон гэрчилгээ, зөвшөөрөл, үнэмлэх;

38.1.2.5.агаарын хөлөг болон аюулгүй байдлын хамааралтай аливаа өгөгдөл, бүртгэл;

38.1.2.6.эдийн засгийн зохицуулалтын дүрмээр шаардах баримт бичиг;

38.1.2.7.хууль, дүрмийн дагуу шаардсан бусад баримт бичиг;

38.1.3.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин болон нийтийн ашиг сонирхолд илтэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд даргын тогтоосон журмын дагуу хяналтын байцаагч агаарын хөлгийг саатуулах;

38.1.4.Даргаас олгосон баримт бичгийг үргэлжлүүлэн ашиглах нь нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтад аюул учруулж болзошгүй тохиолдолд холбогдох этгээдийн иргэний нисэхийн баримт бичгийг түр хураах;

38.1.5.хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгөх;

38.1.6.нисэхийн аюулгүйн хамгаалалт хариуцсан хяналтын байцаагч нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын сорилт хийх;

38.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.”

9/39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг:

“39.1.Хяналтын байцаагч дараах цалин хөлс, хангамж, нийгмийн баталгаагаар хангагдана:

39.1.1.хяналтын байцаагчийн цалинг иргэний нисэхийн салбарын адилтгах бусад албан тушаалын цалингаас багагүйгээр тогтоох бөгөөд хяналтын байцаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор хяналтын байцаагчаар ажилласан хугацааны нэмэгдэл урамшуулал олгоно;

39.1.2.амь нас, эрүүл мэндийг даатгуулна.”

4 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуулийн дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “байдлыг” гэснийг “байдал болон аюулгүйн хамгаалалтыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах” гэснийг “нислэгийн зураг, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын, хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах, зохицуулах” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалтын “стандартын суурь түвшнийг хангах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдлыг зохицуулах” гэснийг “стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг зохицуулах, нийтээр дагаж мөрдөх” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “ерөнхий газрын” гэж, мөн зүйлийн 7.1.6 заалтын дугаарыг “7.1.7” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “төрийн захиргааны төв байгууллагын” гэснийг “Засгийн газрын гишүүний” гэж, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Засгийн газрын гишүүн /цаашид “Сайд” гэх/” гэж, мөн зүйлийн 8.1.4 дэх хэсгийн “дүрмийг” гэснийг “ерөнхий газрын дүрэм” гэж, мөн зүйлийн 8.1.5 дахь заалтын “зохицуулалтыг” гэснийг “зохицуулалтын дүрмийг батлах,” гэж, мөн зүйлийн 8.1.13 дахь заалтын “байцаагч, хяналтын байцаагчийн” гэснийг “байцаагчийн” гэж, 9 дүгээр зүйлийн гарчгийн “Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний чиг үүрэг” гэснийг “Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний чиг үүрэг, бүрэн эрхийн баталгаа” гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “ерөнхий газар” гэж, мөн зүйлийн 9.2.1 дэх заалтын “Иргэний нисэхийн дүрэм боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, бүртгүүлэх” гэснийг “энэ хуулийн 12.1-д заасан дүрэм болон салбарын техникийн баримт бичгийг боловсруулах,” гэж, мөн зүйлийн 9.3 дахь хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадавхтай байна.” гэснийг “ерөнхий газар нь Конвенц, энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн бүрэн чадамжтай байна.” гэж, 10 дугаарын зүйлийн гарчиг, 10.1 дэх хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “ерөнхий газрын” гэж, мөн зүйлийн 10.2.1 дэх заалтын “байдлыг” гэснийг “байдлын хяналт, зохицуулалтыг” гэж, мөн зүйлийн 10.2.3 дахь заалтын “дүрмийн тайлбар, хүсэлт гаргах маягт, бүртгэлийн дэвтэр, техник, технологийн баримт бичгийг батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах” гэснийг “, салбарын техникийн баримт бичиг, дүрэм болон түүнийг дагалдах зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтэр, технологийн баримт бичгийг Конвенцын хавсралтад нийцүүлэн батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах” гэж, мөн зүйлийн 10.2.8 дахь заалтын “хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, зөвшөөрлийг” гэснийг “нисэхийн баримт бичгийг” гэж, 10.2.11 дэх заалтын дугаарыг “10.2.13” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “дүрмийг албадан хэрэгжүүлэх, дүрмийн шаардлагаас чөлөөлөх” гэснийг “дүрэм боловсруулах, дүрмийн шаардлагаас чөлөөлөх болон иргэний нисэхийн хууль, дүрмийг албадан хэрэгжүүлэх” гэж, мөн зүйлийн 12.1.20 дахь заалтын “агаарын навигацийн техникийн үйлчилгээ, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, хэрэглэлийн нислэгийн журам боловсруулах, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн” гэснийг “холбоо, навигаци болон ажиглалтын, нислэгийн хөдөлгөөний, хэрэглэлийн нислэгийн журмын, нисэхийн цаг уурын, нислэгийн зураг, нисэхийн мэдээллийн” гэж, мөн зүйлийн 12.1.21 дэх заалтын “олон улсын гэрээнд” гэснийг “Конвенцын хавсралтад” гэж, мөн зүйлийн 12.1.21 дэх заалтын дугаарыг “12.1.22” гэж, 14 дүгээр

зүйлийн 14.2 дахь хэсгийн “бүртгүүлнэ.” гэснийг “бүртгүүлж, үндэсний харьяаллын болон бүртгэлийн таних тэмдэг авна.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “ерөнхий газраас” гэж, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “агаарын навигацийн” гэснийг “нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, холбоо, навигаци, ажиглалт, нислэгийн зураг, нисэхийн мэдээлэл, хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээг болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах, зохицуулах үйл ажиллагааг” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “хураамжийн орлогоор санхүүжүүлнэ” гэснийг “хураамжаас санхүүжүүлэх бөгөөд Конвенцын заалтын дагуу иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахад зарцуулах агаарын навигацийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэхийг хориглоно.” гэж, мөн зүйлийн 29.2 дахь хэсгийн “орлого” гэснийг “хураамж” гэж, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Сайд” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2.3 дахь заалтын дугаарыг “44.2.4” гэж, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “ерөнхий газар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Төрийн албаны тухай хууль болон” гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 10.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.5.Нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын үйлчилгээг Иргэний нисэхийн тухай хуулийн 27¹.1-д заасан нэгж үзүүлнэ.

10.6.Нисэхийн цаг уурын үйлчилгээний баримт бичгийг Иргэний нисэхийн тухай хуулийн 27¹.2-т заасны дагуу батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 14.8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

14.8 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хууль зөрчих

1.Иргэний нисэхийн багц дүрэмд заасан баримт бичгийн бүрдэлгүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр нисэхийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Иргэний нисэхийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, бүртгэл мэдээллийг засварласан, нөхөн үйлдсэн хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Нислэгийн үед нислэгийг хэвээр үргэлжлүүлэх боломжгүй онцгой тохиолдлын талаар хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдээлээгүй агаарын хөлгийн даргын эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Олон улсын нислэг үйлдэгч агаарын тээвэрлэгч нь зорчигчийн мэдээллийг иргэний агаарын хөлөг хөөрөхөөс өмнө эрх бүхий байгууллагад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүргүүлээгүй, эсхүл мэдээллийг дутуу хүргүүлсэн бол агаарын тээвэрлэгч хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Иргэний нисэхийн хяналтын байцаагчийг хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Иргэний нисэхийн ерөнхий газраас олгосон гэрчилгээ, зөвшөөрөл, үнэмлэх, зэрэглэлээр олгогдсон эрх, хязгаарлалтыг хэтрүүлэн гүйцэтгэсэн хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Иргэний нисэхийн дүрмээр шаардсан баримт бичгийн бүртгэл, хадгалалтын үйл ажиллагааг эрхлээгүй хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Иргэний нисэхийн дүрмээр эсхүл Иргэний нисэхийн ерөнхий газраас шаардсан сургалтын хөтөлбөргүй эсхүл түүнийг хэрэгжүүлээгүй хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглаж буй багаж, тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалт тохируулгыг тогтоосон хуваарийн дагуу хийж гүйцэтгээгүй эсхүл бататгаагүй эсхүл техник үйлчилгээг зохих зааврын дагуу хийгээгүй хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Багийн гишүүдийг томилох зохих шаардлагыг хангаагүй гишүүнийг нислэгт томилсон хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Багийн гишүүдээс бусад ажилтныг зохих сургалтад хамруулж, мэргэшүүлэхгүйгээр нислэгийн үйл ажиллагаанд оролцуулсан хуулийн этгээдийг хорин мянган нэгжээр торгоно.

13.Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтыг хэтрүүлсэн нисгэгчийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Нислэгийн төлөвлөгөөг хаагаагүй эсхүл нисэн ирснээ мэдэгдээгүй агаарын хөлгийн даргыг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Нислэгийн үед Иргэний нисэхийн ерөнхий газраас олгосон хүчин төгөлдөр үнэмлэх, гэрчилгээ эсхүл зөвшөөрлийг биедээ авч яваагүй хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Нислэгийн цагаа худал мэдүүлсэн нисгэгчийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.Нислэгт тэнцэх чадварын шаардлага хангаагүй агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашигласан хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Нислэгт тэнцэх чадварын удирдамжийг гүйцэтгээгүй агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашигласан хүнийг таван мянган, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

19.Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын Ерөнхий заавар, Техник үйлчилгээний хяналтын журам, агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрт холбогдох өөрчлөлт, шинэчлэлтийг хийгээгүй хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

20. Агаарын хөлгийн техник үйлчилгээ, үзлэг болон их засварын цагийн хязгаарлалтыг баримтлаагүй хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

21. Зөвшөөрөлгүй этгээдээр агаарын хөлөгт техник үйлчилгээ гүйцэтгүүлсэн хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22. Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэсэн, эсхүл гүйцэтгэхийг завдсан хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нислэгт томилсон хуулийн этгээдийг хорин таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

23. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тавьсан шаардлагаар согтууруулах ундаа, эмийн бодисын сорил өгөхөөс татгалзсан багийн гишүүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

24. Нислэгийн үе шат бүрд цаг агаарын, агаарын хөлгийн ашиглалтын, аэродром ашиглалтын, ил харааны буюу хэрэглэлийн нислэгийн журам хязгаарлалт хязгаарлалт, эсхүл холбогдох журмыг зөрчсөн агаарын хөлгийн даргыг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрхийг нэг жилийн хугацаагаар хасна.

25. Нислэг хөдөлгөөний удирдлагаас өгсөн зөвшөөрөл эсхүл зааварчилгааг зөрчиж хөөрөлт, буулт үйлдсэн эсхүл зориулалтын бус талбайгаас хөөрөлт, буулт үйлдсэн нисгэгчийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эрхийг нэг жилийн хугацаагаар хасна.

26. Нислэгийн өмнөх үзлэгт нислэгийн бүхээгийн шалгах хуудас ашиглаагүй, агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр, ачааллын манифест, цаг агаарын мэдээ зэргийг шалгаагүй, агаарын хөлөгт үзлэг хийгээгүй болон үзлэгийг зохих ёсоор хийгээгүй үнэмлэх эзэмшигчийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

27. Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаанд:

27.1. Нислэгийн өмнөх мэдээлэл аваагүй;

27.2. Нислэгийн хөдөлгөөний удирдлагын зөвшөөрөл эсхүл зааварчилгаанаас хазайсан, нислэгийн хөдөлгөөний удирдлага ажиллаж байх үед зөвшөөрөлгүйгээр явгалсан, хөөрөх, эсхүл буулт үйлдсэн;

27.3. Хөдөлгүүр нь асаалттай агаарын хөлгийг хараа хяналтгүй орхисон;

27.4. Хөөрч буух зурвас, явгалах зам, эсхүл апроноос гадуур явгалах, зөвшөөрөлгүй шүхрийн үсрэлт хийх боломж олгосон;

27.5. Аэродромын хөдөлгөөний бүсэд радио холбоо бариагүй, аэродромын хөдөлгөөний схемийг мөрдөөгүй, аэродромын хөдөлгөөний бүсэд тогтоосон түвшнийг бариагүй, хөдөлгөөний бүсэд хурдны хязгаарлалтыг хэтрүүлсэн;

27.6. Хэрэглэлийн нислэгийн журам мөрдөөгүй;

27.7.Мөргөлдөхөөс сэргийлэх гэрлээ асаагаагүй, алтиметрийн тохируулгыг зөв хийгээгүй, хаалттай хөөрч буух зурваст буулт, эсхүл хөөрөлт үйлдсэн;

27.8.Агаарын хөлгөөс зөвшөөрөлгүй эд зүйл хаях;

27.9.Агаарын хөлгийг зөвшөөрөлгүй чирэх;

27.10.Хөөрөлт, нислэгийн болон буулт үйлдэх үед агаарын хөлгийн бүхээгт байгаа зорчигч бүрд байх шаардлагатай зөвшөөрөгдсөн суудал болон аюулгүйн бүсгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэсэн;

27.11.Ойртолтын удирдлагын бүсэд зөвшөөрөлгүй, эсхүл зөвшөөрлийг зөрчиж нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэсэн;

27.12.Байгууламж, хүн, эсхүл тээврийн хэрэгсэл дээгүүр шаардлагатай минимум өндрийг бариагүй, мөргөлдөх аюулын шалтгаан болохоор үйл ажиллагаа гүйцэтгэсэн нисгэгчийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

28.Зөвшөөрөлгүйгээр бие даасан нислэг үйлдсэн сурагч нисгэгчийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

29.Зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлсэн эсхүл хөлс, шан урамшуулалтай нислэг үйлдсэн сурагч нисгэгчийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

30.Олон улсын нислэгийн үйл ажиллагаанд оролцсон сурагч нисгэгчийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

31.Нисэхийн сургалтын үйл ажиллагаа эрхлэгч эрхээ хэтрүүлсэн эсхүл худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгаа тараасан бол таван мянган нэгжээр торгоно.

32.Агаараар аюултай ачаа тээвэрлэх дүрэм зөрчиж аюултай ачааг тээвэрлэлтэд хүлээлгэн өгсөн эсхүл тээвэрлэлтэд хүлээн авсан хүнийг таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

33.Сургалт хийж буй агаарын хөлгөөр аюултай ачаа тээвэрлэсэн хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

34.Аэродромын аюулгүйн бүсэд аэродромын үйл ажиллагаа эрхлэгч эсхүл иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр барилгын ажил эхлүүлсэн хүнийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

35.Перрон дээрх хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын журмыг зөрчсөн тээврийн хэрэгслийн жолоочийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

36.Нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

37.Нисэхийн өгөгдөл, нисэхийн мэдээллийг тогтоосон хугацаанд эсхүл үнэн зөвийг баталгаажуулаагүй илгээсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

38.Нисэхийн өгөгдөл, мэдээлэл, нислэгийн зургийг үйл ажиллагаа эрхлэгчийн ерөнхий зааварт тусгагдсаны дагуу зарлан мэдээлээгүй хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

39.Хэрэглэлийн нислэгийн журам зохиолтыг үйл ажиллагаа эрхлэгчийн ерөнхий зааварт тусгагдсаны дагуу хийж гүйцэтгээгүй хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

40.Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний аливаа зөвшөөрөл, зааварчилгааг үйл ажиллагаа эрхлэгчийн ерөнхий зааварт тусгагдсаны дагуу хийж гүйцэтгээгүй хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

41.Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нь иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу эрсдэлийн үнэлгээг хийгээгүй, эрсдэлийн үнэлгээний дагуу холбогдох дараах холбогдох арга хэмжээ аваагүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгоно:

41.1.Эрхэлж буй үйл ажиллагаанд өөрчлөлт орох;

41.2.Шинэ техник, тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

41.3.Ашиглаж буй тоног төхөөрөмж, байгууламжид нэмэлт холболт, суурилуулалт хийхэд эрсдэлийн үнэлгээ хийгээгүй бол найман мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр торгоно.

42.Агаарын хөлөг рүү лазерын гэрэл тусгасан хувь хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх төгрөгөөр, мөн үйлдэл гаргасан нислэгийн ажилтныг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

43.Агаарын хөлгийн бүхээгт:

43.1.Тамхи татсан;

43.2.Агаарын хөлгийн утаа мэдрэгчийг санаатайгаар ажиллагаагүй болгосон;

43.3.Үйл ажиллагаа эрхлэгч үйлчлээгүй согтууруулах ундаа хэрэглэсэн;

43.4.Багийн гишүүний тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

43.5.Агаарын хөлөгт тээвэрлэхийг хориглосон эд зүйл, барааг авч орсон;

43.6.Зөвшөөрөгдсөнөөс бусад үед зөөврийн цахилгаан хэрэгсэл ажиллуулсан хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь хэсгийн "14.7," гэсний дараа "14.8 дугаар зүйлийн 36, 43 дахь хэсэг" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн "14.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг," гэснийг "14.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг," гэж, мөн зүйлийн 6.24 дэх хэсгийн "14.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг" гэснийг "14.8 дугаар зүйлийн 1-4, 6-35, 37-42 дахь хэсэг" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.32 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.4.1, 12.4.2, 12.4.3, 12.4.4 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1.7, 29.1.8, 29.1.11 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн 5.9, 5.10, 5.11 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2, 4.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх үүднээс Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-аас “Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах загвар хууль”-ийг 2013 онд, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хууль”-ийг 2014 онд тус тус боловсруулж, иргэний нисэхийн тухай хууль шинээр болон шинэчлэн боловсруулж байгаа гишүүн улс орнуудад мөрдөж ажиллахыг зөвлөмж болгодог.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 121-т “Монгол Улсын олон улсын гэрээний дагуу нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, үр ашигтай хөгжлийг дэмжихэд чиглэсэн зохицуулалтыг бүрдүүлэх, Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хуульд нийцүүлэх хүрээнд Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурал 2023 онд баталсан.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд бүрэн хэмжээний аудит шалгалтыг Монгол Улсад 2026 оны 4 дүгээр сард хийхээр тогтсон.

Энэхүү аудит шалгалтыг хууль эрх зүйн орчин, иргэний нисэхийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, агаарын навигацийн, нислэгийн, аэродромын үйл ажиллагаа, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт, осол зөрчлийг шинжлэн шалгах, үнэмлэх, гэрчилгээжүүлэлт гэсэн 8 чиглэлээр хийж, олон улсын стандарт, зөвлөмж, дүрэм, журмын хэрэгжилт, түүнд тавьж буй төрийн хяналтын хүрээнд хянан дүгнэдэг.

Уг аудит шалгалтаар хангалтгүй, аюулгүй байдлын ноцтой асуудалтай гэж дүгнэгдвэл эргээд эрхээ сэргээх үйл явц нь бусад орны туршлагаас харахад 10 жилийн хугацаа зарцуулах, нисэхийн салбарын хөгжлийг хойш татсан, өндөр хэмжээний алдагдалд орох эрсдэлтэй.

Практик хэрэгцээ, шаардлага:

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас дээрх бүрэн хэмжээний аудит шалгалтын урьдчилсан шатны үзлэг, шалгалтыг 2025 оны 9 дүгээр сард хийж, Монгол Улс энэхүү шалгалтад бэлэн биш, хангалтгүй үнэлгээ авахаар байгаа талаар анхааруулж, салбарын эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрэм, журмыг шинэчлэх, иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын оновчтой, бие даасан, хараат бус санхүүгийн чадавх бүхий тогтолцоог бүрдүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, сургах дадлагажуулах шаардлагатай талаар зөвлөмж өгсөн.

Тухайлбал, “Монгол Улс Иргэний нисэхийн тухай хуулийг 2023 онд шинэчлэн баталсан хэдий ч энэхүү хуульд конвенцын зохицуулалтуудыг бүрэн тусгаагүй бөгөөд өндөр эрсдэлтэй 9 үл нийцэл байгааг тодорхойлоод, аудит шалгалтаас өмнө

залруулж, конвенцын хавсралтаар тогтоосон стандартад нийцүүлэх, хэрэгжүүлэхийг зөвлөсөн.

Мөн 2025 оны 4 дүгээр улиралд Үндэсний аудитын газраас хийсэн “Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө” аудитын хяналт шалгалтын үр дүнгээр илэрсэн нөхцөл байдлыг арилгах тухай зөвлөмж өгсөн.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 33 дугаар тэмдэглэлээр Олон улсын иргэний нисэхийн байгууллагын аудит шалгалтын бэлтгэл хангах, иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор салбарын эрх зүйн орчныг сайжруулах, шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Зам, тээврийн болон Хууль зүй, дотоод хэргийн сайдад, Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүжилт чадавхыг бүрдүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд, Зам, тээврийн сайд болон Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нарт тус тус даалгасан.

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа:

- Хуулийн төслийн 5 дугаар зүйлээр Агаарын навигацийн үйлчилгээнд нислэгийн зураг, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын, хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах, зохицуулах үйл ажиллагаа хамаарахаар;

- Хуулийн төслийн 7 дугаар зүйлээр Засгийн газрын бүрэн эрхэд иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангахуйц төсөв санхүү, хүний нөөц, цалин хөлсний хэмжээг Конвенцод нийцүүлж батлахаар;

- Хуулийн төслийн 9 дүгээр зүйлээр Иргэний нисэхийн ерөнхий газрын чиг үүрэг, бүрэн эрхийн баталгааг нарийвчлан зохицуулахаар;

- Хуулийн төслийн 21¹ дүгээр зүйлээр Конвенцод нийцүүлэх хүрээнд Агаарын хөлөгт авч явах баримт бичгийг нарийвчлан тодорхойлж нэмж өгсөн;

- Хуулийн төслийн 38 дугаар зүйлээр иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрхэд хяналт шалгалт хийх зорилгоор холбогдох объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх болон нисэхийн баримт бичгийг шаардан гаргуулах, системд нэвтрэх талаар нарийвчлан зохицуулж өгсөн;

- Хуулийн төслийн 39 дүгээр зүйлээр агаарын хөлгийн осол, инцидентийг шинжлэн шалгах хүрээнд Агаарын хөлгийн осол, шинжлэн шалгах ажиллагаа нь Иргэний нисэхийн ерөнхий газар, шүүх шинжилгээ болон бусад байгууллагаас хараат бус байхаар тусгасан.

Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай

хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж хэлэлцүүлэгт оролцогчдоос өгсөн холбогдох саналыг хуулийн төсөлд тусгасан.

---oOo---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн үзэл баримтлалд дурсан хууль зүйн болон практик хэрэгцээ шаардлагын дагуу Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулсан бөгөөд 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2-д заасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн нийт заалтын 50 хувь дотор багтаж байгаа болно.

Хуулийн төслийг Үндэсний аудитын газраас Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн төвийн “Хамтарсан ажиллагааны баг”-аас Монгол Улсад 2026 оны 04 дүгээр сарын 22-ноос 05 дугаар сарын 05-ны өдрүүдэд хийх Иргэний нисэхийн аюулгүй байдлын олон талт хөтөлбөр (USOAP)-ийн аудит шалгалтын бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах 8 чухал элементийн хүрээнд хийсэн урьдчилсан үнэлгээний тайлан болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан аргачлалын дагуу хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судалсан тандан судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны судалгааны тайланг тус тус үндэслэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн төсөлд тусган 38 зүйл, 180 заалтыг хөндсөн нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг Зам, тээврийн яамны цахим хуудаст 30 хоног байршуулж иргэдээс санал авах ажиллагааг хуульд нийцүүлэн зохион байгуулсан болно.

Хамтарсан ажиллагааны багийн урьдчилсан шалгалт: Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Ази, Номхон далайн бүсийн төвийн “Хамтарсан ажиллагааны баг”-аас Монгол Улсад 2026 оны 04 дүгээр сарын 22-нд эхлэх Иргэний нисэхийн аюулгүй байдлын олон талт хөтөлбөр (USOAP)-ийн аудит шалгалтын бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах 8 чухал элементийн хүрээнд урьдчилсан үнэлгээ хийсэн. Үүнд:

Код	Шалгах хүрээ	Конвенцийн хавсралт
LEG	Хууль, эрх зүйн орчин	Хавсралт 19
ORG	Иргэний нисэхийн эрх бүхий байгууллагын бүтэц, зохион байгуулалт	Хавсралт 19
PEL	Нисэхийн үнэмлэхжүүлэлт	Хавсралт 1, 19
OPS	Нислэгийн үйл ажиллагаа	Хавсралт 6, 9, 18, 19 PANS-OPS
AIR	Нислэгт тэнцэх чадварын үйл ажиллагаа	Хавсралт 6, 7, 8, 16, 19
AIG	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах	Хавсралт 13, 19
ANS	Агаарын навигацийн үйлчилгээ	Хавсралт 2, 3, 4, 5, 10, 11, 12, 15, 19 PANS-ATM
AGA	Аэродром, газрын үйлчилгээ	Хавсралт 14, 19

Уг урьдчилсан аудитын хүрээнд хяналтын 8 чиглэлээр өндөр эрсдэлтэй 9 үл нийцэл байгааг тодорхойлоод, түүнийг 2026 оны 04 сарын 22-нд Монгол Улсад эхлэх аудит шалгалтаас өмнө засаж, Конвенцын хавсралтаар тогтоосон стандартад

нийцүүлэх, хэрэгжүүлэх тодорхой зөвлөмжийг нэг бүрчлэн өгсөн болно. Хамтарсан ажиллагааны багийн урьдчилсан шалгалтаар өндөр эрсдэлтэй гэж тогтоогдсон дараах чиглэлүүд байна. Үүнд:

- Иргэний нисэхийн тухай хуульд гишүүн орны иргэний нисэхийн харилцааг зохицуулсан үндсэн зохицуулалт зохих ёсоор тусгагдаагүй, конвенцын шаардлагад нийцээгүй, зөрчилтэй. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байх эрх зүйн статусыг хуулиар тогтоож, баталгааг хангах;

- Салбарын сайд нь СЕ-2 түвшний буюу иргэний нисэхийн дүрмүүдийг баталж, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь СЕ-5 түвшний хяналт шалгалтын заавар журмыг баталж байгаа нь Иргэний нисэхийн ерөнхий газрын бие даасан байх конвенцын шаардлагатай зөрчилдөж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бүх стандарт, зөвлөмжийн нэмэлт өөрчлөлтүүдийг цаг хугацаанд нь иргэний нисэхийн дүрэмд тусгахад сөргөөр нөлөөлж байгаа нь Монгол Улсын нийцэлд ноцтой эрсдэл үүсгэж байна.

- Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэрийг ямар замаар олж авахыг хуульд тодорхой заах;

- Хяналт шалгалтын үйл ажиллагааг ИНЕГ-ын даргаас эрх шилжүүлэн томилсон мэргэшсэн иргэний нисэхийн хяналтын байцаагчид гүйцэтгэх ёстой. ИНЕГ-ын иргэний нисэхийн хяналтын байцаагчид нь хяналт шалгалтыг зохион байгуулахад шаардлагатай сургалтад хамрагдсан байх ёстой ч, одоогийн сургалтын арга нь системтэй биш;

- Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэр, түүний зохион байгуулалт, нисэхийн аюулгүй байдлын хяналтыг үр дүнтэй, тогтвортой явуулахад шаардагдах зохих мэргэшсэн, туршлагатай боловсон хүчнийг бүрдүүлэхэд санхүүгийн болон бусад нөөц хангалттай байх боломжийг салбарын гол хуульд тусгах;

- Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт (СЕ-2) болон техникийн гарын авлага, заавар журам, туслах хэрэгслүүд (СЕ-5)-ийн хүрээнд иргэний нисэхийн дүрэм, журам, аэродромын төлөвлөлтийн шаардлага, үйл ажиллагаа болон нисдэг тэрэгний талбайтай холбоотой журам, зохицуулалтыг цаг хугацаанд нь батлах, шинэчлэх бүрэн эрхтэй байхаар хуульд тусгах;

- Эрх шилжүүлэх тогтолцоог уялдаатай, тодорхой болгох, мөн дүрмийн шаардлагаас чөлөөлөх зохицуулалтыг нэмж тусгах;

- Чикагогийн Конвенц болон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт шаардлагуудын дагуу агаарын хөлөгт авч явах баримт бичиг, нислэгийн бүртгэлийн дэвтэр, аюултай барааны зохицуулалтыг тусгах;

- Нислэгт тэнцэх чадварын дүрэм нь Конвенцын Хавсралт 6, 7, 8, 16-д орсон сүүлийн өөрчлөлтүүдтэй нийцсэн байх ёстой бөгөөд стандартын дагуу цаг алдалгүй шинэчлэх шаардлагатай тул Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь тодорхой

үйл ажиллагааны дүрэм, бусад дагаж мөрдөх журам, заавар, мэдэгдлийг цаг алдалгүй батлах, эсвэл шинэчлэх эрхтэй байхаар тусгах;

- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь гэрч болон шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдол өгөх бусад хүмүүстэй ярилцлага хийх (Протокол асуулт 6.027), Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны тэмдэглэлийн хамгаалалтыг хангах (Протокол асуулт 6.031), Бүхээгийн ярианы бичлэг болон агаарын хөлгийн нислэгийн үеийн өгөгдөл дүрс бичлэгийг нууцлах, задруулахгүй байхыг баталгаажуулах (Протокол асуулт 6.029) талаар зохицуулалтыг тусгах;

- Чикагогийн Конвенцын 1 дүгээр зүйл “Бүрэн эрхт байдал”, 2 дугаар зүйл “Нутаг дэвсгэр”, 12 дугаар зүйл “Нислэгийн дүрэм”, 25 дугаар зүйл “Аюул тулгарсан агаарын хөлөг”-ийн хүрээнд аюул тулгарсан агаарын хөлөгт тусламж үзүүлэх талаар, 3 bis зүйлийн хүрээнд агаарын хөлгийн аюулгүй байдал, зорчигчдын амь насанд аюул учруулахгүй байх талаар тус тус тодорхой зохицуулалт тусгах;

- Монгол Улсын хуулийн нэр томъёоны тодорхойлолтод заасан нэр томъёог Чикагогийн Конвенц болон түүний хавсралтад заасан нэр томъёотой нийцүүлэх болон нислэгийн зургийн үйлчилгээ, хүрээлэн буй орчинд нөлөөлөх иргэний нисэхийн нөлөөллийн талаар заалт оруулах;

- Зөрчил гаргагчид хүлээлгэх хариуцлага, албадлагын арга хэмжээг Иргэний нисэхийн тухай хуульд тодорхой тусгах;

- Иргэний нисэхийн тухай хуульд Иргэний нисэхийн ерөнхий газар нь боловсон хүчний үнэмлэх, агаарын операторын гэрчилгээ, бүртгэлийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, агаарын хөлгийн радио станцын лиценз, аэродромын гэрчилгээ, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон агаарын хөлгийн радио станцын лиценз олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхтэй байхаар, түүнчлэн агаарын хөлөгт авч явах баримт бичгийг хуульд тусгах;

- Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь хяналт шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой дараах объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх, хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор дараах нисэхийн баримт бичигтэй саадгүй танилцаж, шалгах боломжийг хуульчлах;

- Иргэний нисэхийн тухай хуульд Чикагогийн Конвенцын 83 bis зүйлд заасан чиг үүрэг, үүргийг шилжүүлэх тухай зохицуулалт, эрх шилжүүлэх зохицуулалт болон олон улсын навигаци хийж буй агаарын хөлөг бүрд аяллын бүртгэлийн дэвтэр хөтлөх ёстой талаар зохицуулалтыг хуульд нарийвчлан тодорхой тусгах тусгах.

Үндэсний аудитын газраас хийсэн аудит: Үндэсний аудитын газраас Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагаанд аудит хийгээд “*эргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын суурьшил сийрэг, далайд гарцгүй Монгол Улсын хувьд иргэний нисэхийн салбар нь гадаад ертөнцтэй холбогдох үндсэн гарц бөгөөд улс орны хөгжлийн стратегийн чухал тулгуур*”¹ болохыг онцлоод дараах дүгнэлт гаргасан:

¹ УАГ “Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө” тайлангийн 16 дахь тал.

- Төрийн бодлого, тогтолцооны алдаанаас иргэний нисэхийн салбар мэргэшсэн хүний нөөцийн дутагдал, техник технологийн хоцрогдолд орж, олон улсын өмнө хүлээсэн аюулгүй байдлыг хангах үүрэг алдагдах эрсдэлтэй байна;

- Олон улсын гэрээний дагуу үндэсний эрх зүйн орчныг бүрдүүлээгүй, салбарын бодлого, эрх зүйн зохицуулалт, хууль хоорондын нийцэл алдагдсан;

- Агаарын навигацийн үйлчилгээ үзүүлсний хураамжийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа нь салбарын аюулгүй байдал, хяналтын тогтолцоог хангах Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй нөхцөлд хүргэж байна;

- Иргэний нисэхийн ерөнхий газар нь нэг талаас Засгийн газрын агентлаг буюу төрийн захиргааны байгууллага, нөгөө талаас ТӨААТҮГ гэсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, 2 өөр хариуцлагын хэлбэрийг нэг байгууллага хэрэгжүүлснээр эрх олгох, хянах чиг үүрэг, бодлогын хэрэгжилт, салбарын бодлого зохицуулалт, хяналтын чиг үүргийг давхар хэрэгжүүлж, санхүүгийн зохистой удирдлагыг хангахад хүндрэл учруулсан;

- Иргэний нисэхийн салбар нь олон улсын стандартад тулгуурлан аюулгүй, найдвартай нислэгийн үйл ажиллагааг хангах өндөр хариуцлага, нарийн мэргэжлийн зохицуулалт шаарддаг онцгой салбар. Гэтэл Монгол Улс ОУИНБ-д гишүүнээр элссэнээр нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, гэрчилгээжүүлэлт, хяналтын тогтолцоог тасралтгүй сайжруулах үүрэг хүлээж, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад гэрчилгээ олгох, байнгын хяналт шалгалт явуулах мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэшсэн байцаагч, мэргэжилтний нөөц дутагдалтай нь салбарын хяналтын үр нөлөө, аюулгүй ажиллагааны үнэлгээний чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн;

- Иргэний нисэхийн ерөнхий газар нь төрийн захиргааны байгууллагад хамаарч, ажилтан, албан хаагчид нь төрийн жинхэнэ албан хаагч байхаар байна. Гэтэл конвенцын хавсралт 19 “Аюулгүй байдлын удирдлага” болон Doc.10070 “Иргэний нисэхийн аюулгүй байдлын байцаагчийн чадамжийн гарын авлага”-д иргэний нисэхийн байцаагчийн мэдлэг, ур чадвар, чадамж, байцаагчийг ажиллуулах орчин нөхцөл, сургалтын үе шат, чадавхжуулах тогтолцоо, гүйцэтгэлийн үнэлгээ зэргийг нарийвчлан заасан, энэ 2 шаардлага хоорондоо зөрчилдөж байгаа;

- Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад гэрчилгээ олгох, байнгын хяналт шалгалт явуулах мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэшсэн байцаагч, мэргэжилтний нөөц дутагдалтай нь салбарын хяналтын үр нөлөө, аюулгүй ажиллагааны үнэлгээний чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл үүссэн.

Улмаар уг аудитын үр дүнг үндэслэн хуулийн этгээдийн хариуцлагын давхардсан хэлбэрийг арилгах албан шаардлагыг Иргэний нисэхийн ерөнхий газарт, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу иргэний нисэхийн аюулгүй үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас төвлөрүүлж буй орлогыг зориулалтын дагуу зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах албан шаардлагыг Зам, тээврийн сайдад тус тус даалгасны дагуу энэхүү төслийг боловсруулсан болно. Үүнд:

- ✓ Хуулийн төслийн 5 дугаар зүйлээр Иргэний нисэхийн тухай хуулийн нэр томъёог Чикагогийн Конвенцын шаардлагад нийцүүлэх хүрээнд

“зорчигч”, “нисэхийн баримт бичиг”, “ноцтой инцидент”, “улсын нутаг дэвсгэр” зэрэг нэр томъёог шинээр нэмж тусгалаа;

- ✓ Хуулийн төслийн 8 дугаар зүйлээр Салбарын сайд болон Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын чиг үүргийг Конвенцын шаардлагад нийцүүлэхээр холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар;
- ✓ Иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангах, санхүүгийн эх үүсвэрийг Конвенцын шаардлагад нийцүүлэн тодорхой заах замаар дээр дурдсан тайлангуудад дурдсан зөрчлийг хууль зүйн хувьд арилгах, агаарын навигацийн хураамжийн тодорхой хувийг зориулалтын дагуу зарцуулахыг хуулийн төслийн 9 дүгээр зүйлд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал боловсрууллаа;
- ✓ Хуулийн төслийн 9 дүгээр зүйлээр Иргэний нисэхийн салбарын байцаагч болон мэргэжилтнүүдэд Төрийн албаны хууль болон Конвенцын хавсралтаар тавигдаж буй хоорондоо зөрчилтэй шаардлагыг Конвенцын шаардлагад нийцүүлэх хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсрууллаа;
- ✓ Хуулийн төслийн 11 дүгээр зүйлээр Эрх шилжүүлэх зохицуулалтыг Конвенцын шаардлагад нийцүүлэн эрх олгох, эрх шилжүүлэх, итгэмжлэл олгох болгон нарийвчлан өөрчлөн найруулахаар тусгалаа;
- ✓ Иргэний нисэхийн дүрмүүдтэй холбогдох хуулийн зохицуулалтыг Конвенцын шаардлагад нийцүүлэх хүрээнд хуулийн 12 дугаар зүйлийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа;
- ✓ Хуулийн төслийн 14, 21¹ дүгээр зүйлээр Агаарын хөлгийн бүрдэл хэсэг болон агаарын хөлөгт авч явах баримт бичиг, хүрээлэн буй орчны хамгаалалт, агаарын тээвэрлэгчийн болон агаарын хөлгийн даргын үүргийг Конвенцын шаардлагад нийцүүлэх хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа;
- ✓ Хуулийн төслийн 25 дугаар зүйлээр Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь аюул тулгарсан агаарын хөлгийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон хүлээх үүрэг, эрлийн ажиллагааг зогсоохтой холбоотой зохицуулалтыг нэмж тусгалаа;
- ✓ Хуулийн төслийн 27¹ дүгээр зүйлээр Нисэхийн цаг уурын үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын талаар нэмж тусгалаа;
- ✓ Хуулийн төслийн 32 дугаар зүйлээр аэродромын аюулгүйн бүсийг Конвенцын шаардлагад нийцүүлэн холбогдох зохицуулалтыг нэмж тусгалаа;
- ✓ Хуулийн төслийн 38, 39 дугаар зүйлээр Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх, түүний ажиллах нөхцөл, баталгааг Конвенцын шаардлагад нийцүүлэхээр өөрчлөн найрууллаа;

- ✓ Хуулийн төслийн 39¹ дүгээр зүйлээр Иргэний нисэхийн баримт бичиг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зохицуулалтыг Конвенцын шаардлагад нийцүүлэн нэмж тусгалаа;
- ✓ Агаарын хөлгийн осол, хэргийг шинжлэн шалгах байгууллагын тухай ойлголтыг Конвенцын шаардлагад нийцүүлэн хуульд тодруулахаар төсөлд тус тус тусгалаа.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дагавар гарна. Үүнд:

- Олон улсын иргэний нисэхийн байгууллагын бүрэн хэмжээний аудит шалгалтад амжилттай хамрагдах, ингэснээр улс орны хөгжлийн стратегийн чухал тулгуур болсон иргэний нисэхийн салбарын үйл ажиллагааг хөгжүүлэх, улмаар аялал жуулчлал, гадаад худалдаа, эдийн засаг, хамтын ажиллагаа өргөжих;

- Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдал хангагдах, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлж, иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

- Иргэний нисэхийн салбарын мэргэшсэн хүний нөөцийн дутагдал арилах, агаарын навигацийн үйлчилгээний инженерийн дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтыг сайжруулах боломж бүрдэх, зэрэг олон талын зэрэг нөлөө үзүүлнэ.

Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдсэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц, түүний хавсралтууд, холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн, дотоодын холбогдох хууль тогтоомжтой уялдуулан боловсрууллаа.

Мөн Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төслүүдийг дараах байдлаар боловсруулсан болно. Үүнд:

1.Хуулийн төслийн 27¹ дүгээр зүйлд Нисэхийн цаг уурын үйлчилгээ гэсэн зүйл шинээр нэмэгдсэнтэй холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд “Монгол Улсын иргэний агаарын тээврийн хөлгийн баг нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын байдлыг тодорхойлж ус цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагад дамжуулна. Агаарын хөлгөөс цаг уурын мэдээ дамжуулах журмыг төрийн захиргааны байгууллага, иргэний агаарын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран тогтооно” гэж тус тус заасныг “Нислэгийн үед нислэгийн замын дагуух цаг уурын үйлчилгээг Иргэний нисэхийн тухай хуулийн 27¹.1-д заасан нэгж үзүүлнэ”, “Нисэхийн цаг уурын үйлчилгээний баримт бичгийг Иргэний нисэхийн тухай хуулийн 27¹.2-т заасны дагуу батална.” гэж нэмж өөрчлөх төсөл боловсруулсан.

2.Зөрчлийн тухай хуулийн 14.8 дугаар зүйлд заасан Иргэний нисэхийн тухай хууль зөрчих зөрчил хэт ерөнхий тул зөрчлийн төрлийг нэрлэн зааж, түүнд оногдуулах шийтгэлийн хэмжээг гарах эрсдэл, үр дагавартай уялдуулан, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг хэлбэрэлтгүй хангуулахад чиглүүлсэн зохицуулалтуудыг тусгав. Улмаар зарим төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалалд нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийг боловсруулсан.

3.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтад “иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээнээс төвлөрүүлсэн орлого”-оос иргэний нисэхийн ерөнхий газар санхүүжих, 10 дугаар зүйлийн 10.2.11 дэх заалтад “иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох” гэж тусгасан тул Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулж, иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг хүчингүй болгуулах хуулийн төсөл боловсруулсан.

4.Зөвшөөрлийн тухай хуульд заасан 5-10 хоногийн дотор олгож буй зөвшөөрөл нь Иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу олгож буй зөвшөөрлөөс ялгаатай. Өөрөөр хэлбэл учирч болох эрсдэл нь нөхөж баршгүй их бөгөөд хор, хохирол хүний амь нас, цаашлаад улс орны эдийн засаг, дэлхийд эзлэх байр суурьтай салшгүй холбоотой байдаг учир нисэхийн үйл ажиллагаа, үйлчилгээнд үзүүлэх зөвшөөрлийг олон улсын байгууллагаас гаргасан стандарт шаардлагад нийцүүлсэн дүрмийн хүрээнд олгох нь өөрөө нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг хангах үндэс болж байдаг учир бусад энгийн болон тусгай зөвшөөрлөөс ялгаатай байдаг ба Иргэний нисэхийн тухай хуульд Зөвшөөрлийн тухай хуульд заасан зөвшөөрлүүдийг бүрэн зохицуулсан тул Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл тус тус боловсруулсан болно.

---oOo---

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2026 он

АГУУЛГА

1. Асуудлын дүн шинжилгээ, шийдвэрлэх зорилго
2. Зохицуулалтын хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт
3. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө
4. Харьцуулсан дүгнэлт
5. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа
6. Зөвлөмж

Нэг.Асуудлын дүн шинжилгээ, асуудлыг шийдвэрлэх зорилго

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж тус тус заасан.

Монгол Улс нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцод 1989 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ОУИНБ)-ын гишүүн орон болсноор нисэхийн аюулгүй байдлын стандарт, зөвлөмж, шаардлагыг дагаж мөрдөх үүргийг тус байгууллага болон хэлэлцэн тохиролцогч орнуудын өмнө хүлээсэн.

Иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын стандарт, шаардлагад нийцсэн хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоо бүрдүүлэх зорилгоор Иргэний нисэхийн тухай анхдагч хуулийг 1999 онд баталсан нь агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон эрх зүйн үндсийг тавьсан чухал алхам болсон. Улмаар Иргэний нисэхийн тухай хуульд 2001, 2003, 2008, 2011, 2016 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн болно.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас Монгол Улсад 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 05 дугаар сарын 06-ны өдрүүдэд иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын дэлхийн хөтөлбөрийн Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд бүрэн хэмжээний аудит шалгалт хийхээр тогтсон.

Монгол Улс иргэний нисэхийн бүрэн болон хэсэгчилсэн аудит шалгалтад 1997, 1999, 2001, 2010, 2017 онуудад тус тус амжилттай шалгуулж байсан.

Энэхүү аудит шалгалтын үнэлгээ нь тухайн улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй байдлын түвшинг дэлхийд илэрхийлдэг үндсэн шалгуур болдог бөгөөд бага үнэлгээ авах эсхүл ноцтой аюулгүй байдлын асуудалтай гэж тодорхойлогдвол Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрөлтийн нислэг үйлдэгдэхгүй болох, аль ч улс орон руу олон улсын нислэг үйлдэхгүй боломжгүй болох зэргээр Монгол Улсын иргэний нисэхийн салбар өндөр хэмжээний алдагдалд орох юм.

Аудит шалгалтыг хууль эрх зүйн орчин, иргэний нисэхийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, агаарын навигацийн, нислэгийн, аэродромын үйл ажиллагаа, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт, осол зөрчлийг шинжлэн шалгах, үнэмлэх, гэрчилгээжүүлэлт гэсэн 8 чиглэлээр хийж, 851 шалгах асуултын хүрээнд явагдах бөгөөд үүнээс 209 шалгах асуултын дагуу ажлын байранд нотлох баримтыг нарийвчлан үзнэ. Үүнд:

1. Нисэхийн хууль, эрх зүйн чиглэлээр 23 протокол асуулт;
2. Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтын чиглэлээр 12 протокол асуулт;
3. Мэргэжлийн үнэмлэхжүүлэлтийн чиглэлээр 100 протокол асуулт;
4. Нислэгийн үйл ажиллагааны хяналтын чиглэлээр 136 протокол асуулт;

5. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хяналтын чиглэлээр 198 протокол асуулт;
6. Агаарын навигацийн үйлчилгээний хяналтын чиглэлээр 128 протокол асуулт;
7. Аэродром, газрын туслах хэрэгслийн үйлчилгээний хяналтын чиглэлээр 153 протокол асуулт;
8. Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын хэрэгжилтийн чиглэлээр 16 протокол асуулт.

ОУИНБ-аас аудитын шалгах асуултуудад нотлох баримтыг баталгаажуулж, Монгол Улсын иргэний нисэхийн хяналтын тогтолцоо олон улсын стандарт шаардлагад нийцэж байгаа байдлыг үнэлж, нийцлийг оноогоор үнэлэх бөгөөд үнэлгээний оноог олон улсад нээлттэй зарлан мэдээлэх юм.

ОУИНБ-аас дээрх аудит шалгалтын урьдчилсан үзлэг шалгалтыг Монгол Улсад 2025 оны 09 дүгээр сард хийж, 2026 онд хийх аудит шалгалтаас өмнө залруулах шаардлагатай 239 зөвлөмж бүхий тайланг ирүүлсэн.

Тус тайлангаар Иргэний нисэхийн ерөнхий газар (ИНЕГ)-ын статусыг бие даасан, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байлгах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх заалтуудыг Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцод нийцүүлэн Иргэний нисэхийн тухай хуульд шинээр тусган, баталгаажуулах зөвлөмж өгсөн.

Улмаар Чикагогийн конвенц болон түүний хавсралтад заасан стандарт шаардлагууд, иргэний нисэхийн хяналтын байцаагчийн хяналт шалгалтын чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхой тусгах зорилгоор 2023 онд баталсан Иргэний нисэхийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүсэж Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах ажиллагааг мөн хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хийж байна.

ОУИНБ-ын аудит шалгалтад Нисэхийн хууль, эрх зүйн чиглэлээр 23 протокол асуулт байдаг ба дараах агуулгаас бүрдэнэ.

1. Иргэний нисэхийн хууль;
2. ИНЕГ-ын эрх, үүрэг, бүтэц зохион байгуулалт;
3. Иргэний нисэхийн гэрчилгээ, зөвшөөрөл олгох харилцаа;
4. Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын тогтолцоо;
5. Хяналт шалгалт ба албадлагын арга хэмжээ;
6. Маргаан шийдвэрлэлт ба ил тод байдал;
7. ОУИНБ-ын шаардлагад нийцэл.

Иймд аудит шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission)-ийн 2025 оны 09 дүгээр сард хийсэн урьдчилсан үзлэг шалгалтын зөвлөмжөөр өгсөн ИНЕГ-ын газрын статусыг бие даасан, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байлгах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх заалтуудыг Чикагогийн Конвенцод нийцүүлэн Иргэний нисэхийн тухай хуульд шинээр тусган, баталгаажуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулахад хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах нь судалгааны ажлын зорилго оршино.

Хоёр.Зохицуулалтын хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт

Энэхүү судалгааны 1 дэх хэсэгт тодорхойлсон асуудал, түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг арилгах арга замын хувилбарыг зорилгод хүрэх байдал, зардал үр өгөөж, үр нөлөөний байдлаар дараах байдлаар харьцуулан үзэв.

2.1. Асуудлыг зохицуулах хувилбар:

2.1.1. "Тэг" хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах:

2.1.2.Хэвлэл мэдээлэл болон бусад хэрэгслийг ашиглан олон нийтэд хандсан ухуулга сурталчилгааны ажил өрнүүлэх:

2.1.3.Зах зээлийн эдийн засгийн хэрэгслийг ашиглан төрөөс зохицуулалт хийх:

2.1.4.Төрөөс санхүүгийн интервенц хийх:

2.1.5.Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх:

2.1.6.Захиргааны шийдвэр гаргах:

2.1.7.Хуулийн төсөл боловсруулах:

Асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг харьцуулж тоймлон үзвэл:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
"Тэг" хувилбар	Боломжгүй	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Боломжгүй	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй
Захиргааны шийдвэр гаргах	Асуудал нь хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд	Үүсээд байгаа шалтгаан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн	Үр дүнгүй

	захиргааны шийдвэр гаргах замаар шийдвэрлэгдэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд хуулийн хүчин чадлаас дээгүүр захиргааны шийдвэр гарахгүй тул зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission)-аас 2025 оны 09 дүгээр сард Монгол Улсад хийсэн урьдчилсан үзлэг, шалгалтын зөвлөмжийг Иргэний нисэхийн тухай хуульд тусгах нь зорилгыг хангахад үр дүнтэй болно.	Нэмэлт зардал гарахгүй.	Үр дүнтэй.

Хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон эерэг ба сөрөг талыг зардал, үр өгөөжөөр харьцуулсны үр дүнд "хуулийн төсөл боловсруулах" нь асуудлыг шийдвэрлэх ганц хувилбар бөгөөд хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагатай гэж үзсэн тул тандан судлах ажиллагааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Гурав. Зохицуулалтын хувилбарын үр нөлөө

Хуулийн төслийг:

1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг энэ хэсгээр нарийвчлан судаллаа.
 - 3.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө:
 - 3.1.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө: Хуулийн төсөл нь хүний эрхэд аливаа сөрөг нөлөө (хязгаарлах, хориглох) үзүүлэхгүй.
 - 3.1.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө: Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
 - 3.1.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө: Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
 - 3.1.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө: Хууль батлагдсанаар Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдсөн агаарын хөлөг нь Конвенцын 16 дугаар хавсралтад заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байх зохицуулалтыг иргэний нисэхийн тухай хуульд тусгах нь хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

3.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцтэй байдал:

3.2.1. Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцын 37 дугаар зүйлд “хэлэлцэн тохиролцогч улс бүр агаарын хөлөг, ажилтнууд, агаарын шугам, туслах чанарын үйлчилгээнд хамаарах дүрэм, стандарт, журам болон зохион байгуулалтын дээд зэргийн боломжит нэгдмэл байдлыг хангах, ийм нэгдмэл байдлаар агаарын навигацийг дэмжих болон түүнийг сайжруулахад хамаарах бүхий л асуудлаар хамтран ажиллах үүрэг хүлээнэ” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 121-т зааснаар Монгол Улсын олон улсын гэрээний дагуу нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, иргэний нисэхийн аюулгүй байдал, үр ашигтай хөгжлийг дэмжихэд чиглэсэн зохицуулалтыг бүрдүүлэх, ОУИНБ-аас гаргасан Иргэний нисэхийн аюулгүй байдлын загвар хуульд заасантай нийцэж байна.

3.2.2. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуультай нийцсэн бөгөөд Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй юм. Хуулийн төсөлтэй холбогдуулан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Энэ чиглэлээр хуулийн төсөлд шинээр заалт тусгагдахгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш юм.
	1.2. Оролцоог хангах			

	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх			
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон зохицуулалт байхгүй.

3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн зохицуулалт байхгүй.

	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалт тусгаагүй.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуульд ийм зохицуулалт тусгаагүй.
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалын талаарх зохицуулалт тусгаагүй.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулах харилцаа нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэхтэй холбогдох харилцаанд хамаарахгүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар
-------------------	---------------------	---------	---------

1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй, зардлыг бууруулна.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	хөндсөн зохицуулалт бий болох эсэх			
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
7.Хэрэглэгч болон гэр	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

бүлийн төсөв	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Бодит орлого нэмэгдэнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Иргэний нисэхийн ерөнхий газрын статусыг тодорхой болгон хуульчлах, улмаар бүтцийн өөрчлөлт хийгдэнэ.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
10.Макро эдийн засгийн	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.

хүрээнд	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээтэй илүү нийцтэй болно.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалт агуулаагүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэний нисэхийн хяналтын байцаагчдыг мэргэшүүлэх, давтан сургалтад тогтмол хамрагдах боломжтой болно.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Холбогдох стандартыг мөрдөнө.
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Дөрөв. Хувилбарын харьцуулсан дүгнэлт

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу дараах байдлаар дүгнэв:

Шалгуур үзүүлэлт	Зохицуулалтын хувилбар: Хууль тогтоомжийн төсөл боловсруулах Иргэний нисэхийн тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулах эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн зохицуулалт
Зорилгод хүрэх байдал	Монгол Улс ОУИНБ-ын иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын дэлхийн хөтөлбөрийн Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд хийх бүрэн хэмжээний аудит шалгалтад өндөр оноо авч, амжилттай хамрагдсанаар иргэний нисэхийн аюулгүй байдлыг олон улсын стандартад нийцүүлэн хангуулж буйг баталгаажуулах
Хүний эрх, эдийн засаг байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Эергээр нөлөөлнө.
Зардал үр өгөөжийн харьцаа	Хуулийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж гарах бөгөөд нэмэлт зардал гарахгүй
Гарч болох сөрөг үр дагаврыг илрүүлэх	Байхгүй.
Хууль тогтоомжтой нийцтэй эсэх	Нийцтэй.
Тухайн зохицуулалтаар хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Байхгүй.

Тав. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар сонгогдсон тохиолдолд тухайн зохицуулалтын талаарх олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгааг хийнэ.

Тухайн асуудлыг зохицуулсан олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалтад Монгол Улсын олон улсын гэрээ, түүнчлэн тухайн харилцааг зохицуулсан олон улсын гэрээ, хууль тогтоомж, олон улсын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичиг (тогтоол, шийдвэр, тунхаглал г.м), зөвлөмж зэрэг хамаарагдах бөгөөд эдгээр эх сурвалжийн хүрээнд харьцуулан судална.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага:

А. Америкийн Нэгдсэн Улс руу шууд нислэг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд “The Wicks Group Consulting” компанийн үзүүлсэн 2024 оны Зөвлөх үйлчилгээний тайлан,

В. ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн Хамтарсан ажиллагааны баг (CAT

Mission)-ийн 2025 оны урьдчилсан үзлэг шалгалтын тайлан, зөвлөмж.

А. Зөвлөх үйлчилгээний “The Wicks Group Consulting”-ээс 2024 оны 08 дугаар сарын 16-ны өдөр “Хяналт зохицуулалтын орчны хууль эрх зүй, хяналтын тогтолцоог чадавхжуулах” тайлан ирүүлсэн. Тайланд:

- Иргэний нисэхийн хуульд тусгах шаардлагатай зохицуулалтууд;
- Иргэний нисэхийн дүрмийн боловсруулалт, анхаарах асуудал;
- Чикагогийн конвенцын хавсралт 1, 6, 8-д хамааралтай дүрмийн өөрчлөлтөд анхаарах асуудлууд;
- Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, эрх зүйн анхаарах асуудал
- Чикагогийн конвенцын Article 83bis хууль эрх зүй, хариуцлагын асуудал зэргээр нийт 55 зөвлөмж ирүүлсэн.

Үүнээс Иргэний нисэхийн тухай хуульд дараах зохицуулалтуудыг тусгах шаардлагатайг онцолсон. Үүнд:

1. Иргэний нисэхийн тухай хуульд албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, албадлагын арга хэмжээг ямар байгууллага, ямар албан тушаалтан хариуцах нь тодорхой бус;
2. Иргэний нисэхийн ерөнхий газраас гаргасан аливаа шийдвэрүүдийг шүүх (judicial review) хянан шалгаж, тухайн шийдвэр нь хууль зөрчсөн эсэхийг тогтоох үйл явцын талаар тодорхой зохицуулалт байхгүй;
3. Өөрийн бүтэц зохион байгуулалтаас гадуурх хувь хүн, хуулийн этгээдэд хяналтын тодорхой чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх, итгэмжлэх (тухайлбал нисэхийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн чадавхыг үнэлэх эрх), томилох эрхтэй байхыг хуульд тодорхой, илэрхий заагаагүй;
4. Конвенцын заалт болон ОУИНБ-ын шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд хуульд тодорхой, нарийвчилсан зохицуулалтуудыг тусгах шаардлагатай, FAA model болон бусад улс орны хуулиудаас санаа авахдаа тухайн орны хууль эрх зүйн тогтолцоо, засаглал болон Монгол улсын тогтолцооны талаар харгалзан үзэх шаардлагатай;
5. Чикагогийн конвенцын хүрээнд дараах 25 зүйлийн зохицуулалт хуульд тусгагдсан байх шаардлагатай.
 1. Улс бүрийн агаарын орон зайд бүрэн эрхт байдлыг хүлээн зөвшөөрөх;
 2. Иргэний нисэх онгоц болон улсын нисэх онгоцыг ялгах;
 3. Нислэгийн үеэр иргэний нисэх онгоцны эсрэг зэвсэг хэрэглэхгүй байх, саад учруулсан тохиолдолд онгоцонд байгаа хүмүүсийн амь насанд аюул учруулахгүй байх. Зөвшөөрөлгүйгээр нисэж буй иргэний нисэх онгоцыг тогтоосон нисэх онгоцны буудалд буухыг шаардах эрх, эсвэл Конвенцын зорилгод нийцэхгүй гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд;
 4. Тусгай зөвшөөрөлгүйгээр нисгэгчгүй нисэх онгоцыг нутаг дэвсгэр дээгүүр нисэхийг хориглох;
 5. Онцгой нөхцөл байдал, онцгой байдал, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүднээс улсын нутаг дэвсгэр дээгүүр нисэхийг түр хугацаагаар хязгаарлах эсвэл хориглох эрх;

6. Нислэг, маневртай холбоотой дүрэм журмыг дагаж мөрдөхийг хангах улсын үүрэг;
 7. Өвчний тархалтыг урьдчилан сэргийлэх заалтууд;
 8. Нисэх онгоцны буудал болон үүнтэй төстэй төлбөр;
 9. Бусад улсын нисэх онгоцыг газардах эсвэл хөөрөх үед нэгжлэг хийх, гэрчилгээ, баримт бичгийг шалгах эрх;
 10. Давхар бүртгэлийг хориглох;
 11. Олон улсын навигацид нисэх онгоцны тэмдгийг харуулах;
 12. Бүртгэлийн талаар мэдээлэх;
 13. Осолд орсон нисэх онгоцны талаарх заалтууд;
 14. Ослын мөрдөн байцаалт;
 15. Олон улсын навигацид оролцож буй нисэх онгоцонд авч явах баримт бичиг;
 16. Агаарын хөлгийн радио тоног төхөөрөмж;
 17. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ;
 18. Ажилтнуудын үнэмлэх болон Хэлэлцэн тохирогч улсууд хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрх;
 19. Гэрчилгээ, лицензийг хүлээн зөвшөөрөх;
 20. Байлдааны зориулалттай зэвсгийн ачааны хязгаарлалт;
 21. Гэрчилгээ, лицензийг батлах;
 22. Нислэгт тэнцэх чадварын одоогийн стандартыг хүлээн зөвшөөрөх;
 23. Ажилтнуудын чадамжийн одоогийн стандартыг хүлээн зөвшөөрөх;
 24. Шинэ зохицуулалтыг бүртгэх;
 25. Агаарын хөлгийг түрээслэх, түрээслэх эсвэл солилцох тохиолдолд тодорхой чиг үүрэг, үүргийг шилжүүлэх.
6. Чикагогийн Конвенцын 83bis зүйлд хамаарах нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын эрх, үүргийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Иргэний нисэхийн тухай хуульд тусгах. Эрх шилжүүлэх гэрээний талаарх нарийвчилсан зохицуулалт хуульд байхгүй зэрэг болно.

В. ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн төвийн Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission)-ийн зөвлөмж

1. Чикагогийн конвенцын холбогдох зүйл заалт Иргэний нисэхийн хуульд бүрэн туссан эсэх, хэрхэн туссан асуудлаар харьцуулсан шинжилгээ буюу Mapping Matrix боловсруулах;
2. Чикагогийн конвенц болон ОУИНБ-ын бодлого, баримт бичгүүдэд тусгагдсаны дагуу ИНЕГ нь санхүүгийн хувьд бие даасан, хараат бус, бүрэн эрхт байдлаар ажиллах зохицуулалтыг хуульд тусгах;
3. Конвенцын зүйл заалтын нэр томъёотой уялдуулан хуулийн нэр томъёо, хэллэгийг засварлах;
4. Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааг ямар эх үүсвэрээс хэрхэн санхүүжүүлэх асуудлыг хуульд тодорхой тусгах;
5. Чикагогийн конвенцын Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвартай холбоотой зүйл заалтуудыг хуульд бүрэн тусгах;
6. Агаарын хөлгийн Радио станцын тусгай зөвшөөрөл (Radio station license) олгох, сунгах, түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг Иргэний нисэхийн тухай хуульд хуульд тусгах. (хуульд тусгаагүй боловч ИНЕГ олгож буй);
7. Чикагогийн конвенцын Хавсралт 16 Хүрээлэн буй орчны хамгаалалтын асуудлыг хуульд тусгах;

8. Иргэний нисэхийн тухай хуулийн 10 дугаар зүйлд тусгагдсан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үндсэн чиг үүрэг, эрхийн асуудлыг ОУИНБ-ын Док 9734 3.1, Док 8335 3.2 дугаар заалтад нийцүүлэн шинэчлэх;
9. Иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтын хүрээнд нэмэлт удирдамж, тушаал шийдвэр гаргах, хяналт хэрэгжүүлэх эрхийг хуульд тодорхой тусгах;
10. Иргэний нисэхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийг өөрчлөн найруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй болгохын тулд зөрчил шалган шийдвэрлэх болон тухайн зөрчлийн шинж чанараас хамаарч ямар арга хэмжээ, торгууль авахыг тусгах;
11. Мэргэжлийн үнэмлэх, Гэрчилгээ, Зөвшөөрөл, Батламж, Эрх олголт буюу иргэний нисэхийн холбогдох баримт бичгийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хязгаарлалт тогтоох зэрэг ялгаатай зохицуулалтуудыг Иргэний нисэхийн тухай хуульд тодорхой, дэлгэрэнгүй тусгах;

Ази, Номхон далайн бүсийн төвийн Хамтарсан ажиллагааны багийн (CAT Mission)-аас тайланд дараах зөвлөмжийг мөн дэлгэрэнгүй тусгасан. Үүнд:

/"CE-1: Нисэхийн үндсэн хууль, тогтоомж", "CE-2: Үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт", "CE-5: Техникийн гарын авлага, заавар журам болон туслах хэрэгслүүд"/

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь иргэний нисэхийн дүрэм батлах бүрэн эрхтэй байх нь нисэхийн аюулгүй байдлыг хангахад цаг хугацааны хувьд чухал ач холбогдолтой. Хэрэв шалгуур үзүүлэлт буюу CE-2 түвшний иргэний нисэхийн дүрэм батлах эрх Зам, тээврийн Сайдын түвшинд хэвээр үлдвэл, CE-1 болон CE-2 түвшний хооронд үл нийцэл үүссээр байх эрсдэлтэй;
2. "Шилжүүлэх" (Transferred) болон "Эрх шилжүүлэх" (Delegated) гэдэг нь хуулийн хувьд ижил утгатай үг биш. Эрх шилжүүлэх тогтолцоо уялдаагүй байгаа одоогийн нөхцөл байдал нь Засгийн газраас Зам, тээврийн яам руу, Яамнаас Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга руу гэсэн гурван шатлалтай мэт харагдаж байна. Гэвч ИНЕГ-ын даргаас ИНЕГ-ын иргэний нисэхийн хяналтын байцаагчдад шилжих эрх мэдлийн зохицуулалт тодорхойгүй байна;
3. Иргэний нисэхийн хяналтын байцаагчдад хяналт шалгалт, аудит, үзлэг шалгалт зэрэг үйл ажиллагаа явуулах эрх олгох заалтуудыг Иргэний нисэхийн тухай хуульд тусгах шаардлагатай;
4. Хуулиар зохицуулах (Binding) болон хуулиар зохицуулахгүй (Non-Binding) зохицуулалтын хүрээнд гардаг тушаал, албан даалгавар, албан бичиг, зааварчилгаа, аюулгүй байдал/хамгаалалтын зөвлөмж, хэвлэл, товхимол зэрэг баримт бичгүүдийн статусыг тодорхой болгох шаардлагатай;
5. ОУИНБ-ын "Filing of Differences" болон Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-тэй холбоотой асуудлуудыг Иргэний нисэхийн тухай хуульд тодорхой тусгаж, дараагийн CE-2 болон CE-5 түвшинд дэлгэрүүлэн боловсруулах шаардлагатай;
6. Иргэний нисэхийн тухай хуульд дүрмийн шаардлагаас чөлөөлөх үндсэн зохицуулалтыг тусгаагүйгээс эрх мэдэл тодорхой бус болох нөхцөл үүссэн байна;
7. Иргэний нисэхийн тухай хуульд хяналтын байцаагчдын саадгүй нэвтрэх эрхтэй газруудыг тодорхой зааж тусгах;
8. Иргэний нисэхийн тухай хуульд иргэний нисэхийн хяналтын байцаагчид

өөрийн чиг үүргийн дагуу нисэхийн холбогдох баримт бичгүүдэд (жишээлбэл: гарын авлага, гэрчилгээ, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, журам, техникийн баримт бичиг, ажилтны хувийн хэрэг, ажилтны үнэмлэх гэх мэт) хандаж үзлэг хийх эрх олгох зохицуулалт тусгагдаагүй;

9. Агаарын хөлөгт авч явах ёстой баримт бичгүүдийн тухай зохицуулалт Иргэний нисэхийн тухай хууль, иргэний нисэхийн дүрэмд тусгагдаагүй;
10. Монгол Улсад Чикагогийн Конвенцын 3 bis болон 83 bis дугаар зүйлсийг тусгасан ерөнхий буюу “umbrella” заалтуудыг Иргэний нисэхийн тухай хуульд (СЕ-1 түвшинд) нэвтрүүлэхийг санал болгож байна. Мөн хэрэгжилтийг хангах зорилгоор иргэний нисэхийн дүрэмд илүү нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаж, боловсруулах нь зүйтэй;
11. Зөрчлийн түвшин, шинж чанарт тохирсон албадлагын арга хэмжээний зохицуулалтыг Иргэний нисэхийн тухай хуульд тодорхой тусгах, үүний дагуу иргэний нисэхийн дүрэм боловсруулах, зэрэг болно.

Дээрх зөвлөмжүүдийн нийцлийг хангаж, зөвлөсөн асуудлуудаар Монгол улс Иргэний нисэхийн тухай хуульд тус бүрчлэн зохицуулалтуудыг тусгаснаар олон улсын шаардлагад нийцсэн иргэний нисэхийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхээр байна.

Олон улсын иргэний нисэхийн загвар хууль нь иргэний нисэхийн салбарт улс орнууд дотоодын хууль тогтоомжоо боловсруулах, шинэчлэхдээ жишиг болгон ашиглахад зориулсан хууль зүйн баримт бичиг юм. Энэ нь шууд хүчин төгөлдөр үйлчилдэг хууль биш, харин улс орнуудын хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэхэд чиглэсэн загвар (model) хууль байна.

Зургаа. Зөвлөмж

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах зохицуулалтын хувилбар нь одоогийн нөхцөлд дэвшүүлсэн зорилгыг хангах хамгийн боломжит хувилбар бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, хүний эрх, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь байж болох хэмжээнээс хэтрэхгүй болно.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц болон дээрх загвар хуульд нийцүүлэн шинэчилснээр Монгол Улс ОУИНБ-аас иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын дэлхийн хөтөлбөрийн Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд хийх бүрэн хэмжээний аудит шалгалтад амжилттай хамрагдах үндэслэл болохоор байна.

---oOo---

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

**(ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ)**

УЛААНБААТАР ХОТ
2026 ОН

АГУУЛГА

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хоёр. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо:

2.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох

Гурав. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо:

3.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;

3.2.Нэг бүрийн зардлыг тооцох;

3.3.Тоон үзүүлэлтийг тооцох;

3.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;

3.5.Хялбарчлах боломжийг шалгах;

3.6.Нэмэлт зардлыг тооцох.

Дөрөв. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдан гарснаар төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо:

4.1.Төрийн байгууллагад шинээр нэмэгдэж байгаа болон өргөжиж байгаа чиг үүргийг тогтоох;

4.2.Үүргийг хэрэгжүүлэхтэй хүний нөөцийн зардлыг тооцоолох;

4.3.Үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах материаллаг зардлыг тооцоолох;

4.4.Үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох бусад зардлыг тооцоолох Зардлыг нэгтгэн тооцох.

Тав. Дүгнэлт

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд шинээр үүсэх үүрэг болон тэдгээрийг дагалдан гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг баримтлан зардлын тооцоог гаргав.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “Хуулийн төсөл” гэх) батлагдсанаар зардал тээгч хуулийн этгээд болон төрийн байгууллагад тодорхой төрлийн зардал үүсгэхээр байна.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлохдоо уг хуулийн төсөл нь “нэмэлт, өөрчлөлт” хэлбэрээр бичигдэж байгаа буюу иргэний нисэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуультай, түүний дагуу холбогдох иргэн, хуулийн этгээд, байгууллага тухайн хуулийг мөрдөн хэрэгжүүлж байна. Иймд зардлын тооцооллыг зөвхөн уг хуулийн төсөлд тусгасан шинээр бий болгох үүрэг, түүнчлэн өмнө хэрэгжүүлж байсан үүргийг өргөжүүлсэнтэй холбоотой үүсэх зардлыг тооцоолсон болно.

Хуулийн төслөөр шинээр бий болж буй үүрэгт зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, түүнд үндэслэн баримжаалах, салбарын мэргэжилтнүүдээс санал авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

ХОЁР.ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үйлчлэлд хамаарахаар заасан иргэнд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн.

холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;

Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслөөс үзэхэд иргэнд үүсэх цаг хугацааны болон мөнгөн зардал бий болгосон зохицуулалт нэмэгдээгүй, өөрчлөгдөөгүй байна. Иймд тусгайлан зардал тооцох хэрэгцээ, шаардлага байхгүй байна.

ГУРАВ.ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн төслийн үйлчлэлд хамаарахаар заасан хуулийн этгээдүүд иргэний нисэхийн үйл ажиллагаа явуулахад тэдэнд үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана.

Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- нэг бүрийн зардлыг тооцох;
- тоон үзүүлэлтийг тооцох;
- нийт зардлын дүнг тооцож гаргах;
- хялбарчлах боломжийг шалгах;
- нэмэлт зардлыг тооцох.

3.1.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙГ ТОГТООХ:

Хуулийн төслөөр хуулийн этгээд нь дараах үүрэг нэмэлтээр хүлээхээр байна.
Үүнд:

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга
1	15 ¹ .1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.	Хуулийн этгээд нь нислэгийн үйл ажиллагаандаа ашиглах агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрүүлэх бол хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.
2	19 ¹ .1.Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эд хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болзошгүй аюултай барааг агаарын хөлгөөр тээвэрлэх, тээвэрлэлтэд бэлтгэж хүлээлгэн өгөх үйл ажиллагааг Иргэний нисэхийн дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн этгээдээр гүйцэтгүүлнэ.	Аюултай барааг агаарын хөлгөөр тээвэрлэх, тээвэрлэлтэд бэлтгэж хүлээлгэн өгөх үйл ажиллагааг гүйцэтгэх хуулийн этгээд нь Иргэний нисэхийн дүрмээр тавигдах шаардлагыг хангасан байна.
3	21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална. 21.6.Гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөг албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд агаарын хөлгийн дарга тухайн улсын эрх бүхий байгууллагаас холбоогоор болон саатуулагч агаарын хөлгөөс анхааруулга, эсхүл бусад дохиогоор өгсөн шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.	Агаарын хөлгийн даргын үүрэг дээр гадаад улсад нислэг үйлдэж байгаа бол тухайн улсын дүрэм, журмыг мөрдөн ажиллана. Тухайн улсын дүрэм, журмыг мөрдөөгүйгээс агаарын хөлөг албадан саатуулагдсан тохиолдолд агаарын хөлгийн даргын тухайн улсын эрх бүхий байгууллагаас холбоогоор болон саатуулагч агаарын хөлгөөс анхааруулга, эсхүл бусад дохиогоор өгсөн шаардлагыг дагаж мөрдөнө.
4	21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байна.	Нислэгийн дэвтрийг бүрэн хөтлөх талаар иргэний нисэхийн дүрэмд орж, хэрэгжилт байгаа ба Конвенцын заалтын дагуу орж, агаарын хөлгийг даргын үүргийг хуульчилсан.
5	21 ¹ .1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно: 21 ¹ .1.1.агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;	Иргэний нисэхийн дүрмээр шаардсан эдгээр баримт бичиг олгогдож, бүрдүүлэлт хийгддэг, хэрэгжилт байгаа ба Конвенцын 29 дүгээр зүйлийн дагуу хуульчилсан.

	<p>21¹.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөл;</p> <p>21¹.1.3.хэрэв радио төхөөрөмжөөр тоноглогдсон бол агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;</p> <p>21¹.1.4.багийн гишүүн бүрийн холбогдох хүчинтэй үнэмлэх;</p> <p>21¹.1.5.нислэгийн бүртгэлийн дэвтэр, эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт;</p> <p>21¹.1.6.хэрэв зорчигч тээвэрлэж яваа бол тэдний нэрийн жагсаалт, суусан болон очих газар;</p> <p>21¹.1.7.хэрэв ачаа тээвэрлэж яваа бол тусгай ачааллын мэдээлэл агуулсан ачааны манифест;</p> <p>21¹.1.8.иргэний нисэхийн дүрмээр шаардсан бусад баримт бичиг.”</p>	
6	<p>25.4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь аюул тулгарсан агаарын хөлгийн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.</p> <p>25.5.Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын нисэхийн байгууллагатай хамтран гүйцэтгэж болно. Улсын нисэхийн тухай хуулийн 4.1.2-т заасан аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх аливаа арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигчийн саналыг үндэслэн Засгийн газар гаргана.</p>	

3.2.НЭГ БҮРИЙН ЗАРДЛЫГ ТООЦОХ

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд нэг хуулийн этгээдээс зарцуулах мөнгөн зардлыг тооцоолон гаргана. Ингэхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт хуулийн этгээдийн ажилтантай уулзалт ярилцлага хийх дүнд бий болсон үр дүнг ашигласан болно.

Хүснэгт 2

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	15 ¹ .1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын Хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.	Хуулийн этгээд нь нислэгийн үйл ажиллагаа явуулахдаа хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан агаарын хөлгийн зөвшөөрлийг авснаар нислэгийн зөвшөөрлийг авна.	Үүрэгтэй танилцах, судлах (Олон улсын стандарт болон монгол улсын иргэний нисэхийн холбогдох стандартыг тодорхойлно.)	120 мин
			Мэдээлэл цуглуулах (Ашиглах агаарын хөлгийн маяг, хөдөлгүүр нь холбогдох стандартыг хангаж буй эсэхийг шалгана)	120 мин
			Тоо баримтыг боловсруулах (Үйлдвэрлэгчээс олгосон байгаль орчны нийцлийн баримт бичгийг бүрдүүлнэ)	120 мин
			Хүсэлт гаргах (Бүрдүүлсэн баримт бичгийг үндэсний эрх бүхий байгууллагад хүргүүлж маяг хүлээн зөвшөөрүүлэх хүсэлт гаргана)	30 мин
			Эрх бүхий байгууллагаас байгаль орчны стандарт хангасан тухай баталгаажуулалт, зөвшөөрөл авна.	30 мин
			Ашиглалтын үеийн байгаль орчны нийцлийн дотоод хяналт хийх	120 мин

	Нийт хугацаа	540 мин
--	---------------------	----------------

Хүснэгт 3

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
2	<p>21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална.</p> <p>21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байна.</p>	<p>Нислэгийн үйл ажиллагаа нь тухайн бүс нутгийн дүрэм журмыг мөрдөн ажиллах ба агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийг хөтөлнө.</p>	Нислэгийн өмнө тухайн улсын агаарын зайд мөрдөгдөх дүрэм, журмыг судалж тодорхойлно.	60 мин
			Нислэгийн төлөвлөгөө, ажиллагаа тухайн улсын шаардлагад нийцэж байгаа эсэхийг холбогдох ажилтнууд шалгана.	60 мин
			Багийн гишүүдэд тухайн улсын онцгой шаардлага, хязгаарлалтыг танилцуулна.	20 мин
			Нислэгийн явцад тухайн улсын хүчин төгөлдөр дүрэм, журмыг мөрдөн, агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийг хөтөлнө.	30 мин
Нийт хугацаа				170 мин

д/д	Гүйцэтгэх үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
3	<p>21¹.1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно</p> <p>21¹.1.1.агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;</p> <p>21¹.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөл;</p> <p>21¹.1.3.хэрэв радио төхөөрөмжөөр тоноглогдсон бол агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;</p> <p>21¹.1.4.багийн гишүүн бүрийн холбогдох хүчинтэй үнэмлэх;</p>	<p>Агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээг авах</p>	Агаарын хөлгийн өмчлөл, гарал үүслийн баримтыг бүрдүүлэх	60 мин
			Улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах	60 мин
			Бүртгэлийн гэрчилгээ авах	20 мин
		<p>Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ / тусгай зөвшөөрөл авах</p>	Хүсэлт гаргах	30 мин
			Техникийн үзлэг, шалгалт	120 мин
			Баримт бичгийн нийцлийг шалгах	60 мин
			Гэрчилгээ / зөвшөөрөл авах	30 мин
Радио холбооны гэрчилгээ авах	Радио төхөөрөмжийг суурилуулах	60мин		

21 ¹ .1.5.нислэгийн бүртгэлийн дэвтэр, эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт; 21 ¹ .1.6.хэрэв зорчигч тээвэрлэж яваа бол тэдний нэрийн жагсаалт, суусан болон очих газар; 21 ¹ .1.7.хэрэв ачаа тээвэрлэж яваа бол тусгай ачааллын мэдээлэл агуулсан ачааны манифест; 21 ¹ .1.8.иргэний нисэхийн дүрмээр шаардсан бусад баримт бичиг.”		Давтамж, ажиллагаа шалгах	30 мин
		Хүсэлт гаргах	30 мин
		Гэрчилгээ авах	30 мин
	Багийн гишүүдийн үнэмлэх олгох	Багийн гишүүдийг сургалтад хамруулах	60 мин
		Мэргэжлийн шалгалт	30 мин
		Үнэмлэх өгөх	20 мин
	Зорчигчийн нэрийн жагсаалт гаргах	Зорчигчдын мэдээллийг бүртгэх	240 мин
		Суусан ба очих газрыг тодорхойлох	60 мин
		Баримтад хавсаргах	30 мин
	Ачааны манифест	Ачааны жин, төрөл, байрлал тодорхойлох	60 мин
		Тооцоог баталгаажуулах	30 мин
		Манифест боловсруулах	30 мин
Нийт хугацаа			1090 мин

Хуулийн этгээдэд үүсэж байгаа хоёр төрлийн үүргийг хэрэгжүүлэхийн тулд үйлдэлд суурилсан арга ашиглан, зардлын тооцоо бодох аргачлалд заасан үйлдэл бүрд зарцуулах хугацааг удирдлага болгон нийт зарцуулах хугацааг үүрэг тус бүрээр гаргав.

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа дундаж ажилтанд олгох сарын үндсэн цалинг Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг ажилтны ажиллах цагийн горимоор тогтоосон хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргана.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар² “2025 оны 3 дугаар улирлын байдлаар тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарын ажиллагсдын сарын цалин 3.116.000 төгрөг байх тул уг тоог үндсэн суурь болгон ашиглана.

Ажиллах хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд³ заасан ажлын цагийг баримтлав.

²<https://www.1212.mn> Үндэсний статистикийн хорооны албан ёсны веб хуудаст байршуулсан цалин хөлсний талаарх судалгаа

³ Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Төрийн мэдээлэл сэтгүүлийн 1999 оны №25 дугаарт хэвлэгдсэн.

Хүснэгт 4

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
3.116.000 : 22 өдөр : 8 цаг = 17.704.5 төгрөг /нэг цагийн ажлын дундаж хөлс/ 17.704.5 : 60 минут = 295 төгрөг /нэг минутын цалин/

Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд нэг хуулийн этгээдэд үүсгэж байгаа зардлыг үйл ажиллагаанд буюу үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйлдэлд зарцуулж буй хугацааг ажлын хөлсөөр үржүүлэх замаар тооцоолно.

Хүснэгт 5

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	15 ¹ .1.Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.	540 мин	295 төгрөг	159,300 төгрөг
2	21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална. 21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байна.	170 мин	295 төгрөг	50,150 төгрөг
3	21 ¹ .1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно.	1090 мин	295 төгрөг	321,550 төгрөг

3.3.ТООН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон үүргийг хэдэн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргана.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.5.2-д заасны дагуу тохиолдлын тоо нь тухайн үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлнэ гэж заасан. Иргэний нисэхийн 2025 оны 12 дугаар сарын статистикаар Монголын иргэний нисэхийн салбарт зорчигч тээврийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй дотоодын 4, гадаадын 15 компани байгаа бөгөөд Иргэний нисэхийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх үүрэг бүхий гадаад, дотоодын нийт 19 компанийг тохиолдлын тоо болгон ашиглана.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд **тохиолдлын тоо**⁴ болон **давтамжийг**⁵ холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм. Давтамжийн хувьд Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.5.3-т давтамжийн тоо нь тухайн үүргийг гүйцэтгэх хуулийн этгээд 1 жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг харуулна гэж заасны дагуу хүрээлэн буй орчны стандарт хангасан агаарын хөлгийг сонгох, нисэх зөвшөөрөл авах холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх зэрэг нь 1 удаагийн шинжтэй тул давтамжийг 1 гэж үзнэ.

ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ = ТООН ҮЗҮҮЛЭЛТ

Дээрх томъёог ашиглан Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар шинээр хоёр төрлийн зөвшөөрөл авах үүргийн тоон үзүүлэлтийг тогтооно.

Хүснэгт 6

д/д	Гүйцэтгэх үүрэг	Тохиолдлын тоо	x	Давтамж	=	Тоон үзүүлэлт
1	15 ¹ .1.Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын Хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.	17	x	1	=	17
2	21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална. 21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байна.	17	x	1	=	17
3	21 ¹ .1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно.	17	x	1	=	17

⁴ “Тохиолдлын тоо” гэдэг нь тухайн шинээр бий болж байгаа үүргийг хэдэн хуулийн этгээдэд хүлээлгэж байгааг илэрхийлэх тоог ойлгоно.

⁵ “Давтамж” гэдэг нь тухайн үүргийг биелүүлэх хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж байгууллага уг үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэхийг илэрхийлэх тоо юм.

3.4.НИЙТ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫН ДҮНГ ТООЦОЖ ГАРГАХ:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүргийн нийт зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлснээр гаргах юм.

НЭГ БҮРИЙН ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ = НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 7

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	x	Тоон үзүүлэлт	=	Нийт зардал ⁶	
1	15 ¹ .1.Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын Хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.	159,300 төгрөг	x	17	=	2,708,100 төг	
2	21.5.Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга тухайн улсын агаарын зайд хамаарах хүчин төгөлдөр хууль, дүрэм, журмыг баримтална. 21.7.Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтөлсөн байна.	50,150 төгрөг	x	17	=	852,550 төг	
3	21 ¹ .1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно.	330,400 төгрөг	x	17		5,616,800 төг	
	Нийт						9,177,450 төг

3.5.ХУВИЛБАРЫГ НЯГТАЛЖ, ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

Хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн хувьд Иргэний нисэхийн тухай хуульд зааснаар нислэгийн зөвшөөрөл, нислэгийн холбогдох стандартыг хангаж ажиллах шаардлагатай болж байгаатай холбоотой үүргийг тухайн аж ахуйн нэгж байгууллага гүйцэтгэхэд ямар хэмжээний зардал гарахыг өмнөх шатанд үйлдэлд суурилсан өртөг тооцох аргачлалын дагуу тооцоолсон болно.

⁶ “Нийт зардал” гэдэг нь уг хуулийн төсөл батлагдан гарснаар хуулийн төсөлд тусгагдсан үүргийг биелүүлэх нийт хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал юм.

Энэ үүргийг хялбарчлах болон хөнгөвчлөх, бусад үүрэгтэй хавсаргах боломжгүй бөгөөд Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц болон иргэний нисэхийн тухай хуулиар нэгэнт зохицуулагдсан байна. Түүнчлэн Хуулийн төсөлд иргэний нисэхийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүндрүүлэх ямар нэг зохицуулалт агуулаагүй тул хуулийн төслийн зохицуулалтын дагуу үүсэх үүргийн хуулийн этгээдэд үүсэх зардал нь боломжит хэмжээнд байна гэж дүгнэж байна.

3.6.НЭМЭЛТ ЗАРДЛЫГ ТООЦОХ:

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдээс хуульд заасан үүргийг биелүүлэхийн тулд зайлшгүй төлөхөөр хуулиар тогтоосон төлбөр хураамж, тоног төхөөрөмж, материал зэргийг нэмэлт зардал гэсэн ойлголтод хамруулж ойлгох бөгөөд дараах нэмэлт зардал гарна. Үүнд:

- Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 10.2.11-д иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоосноос гарах зардал
- Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 32.4-т заасан аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн барилга, байгууламж, талбай, объектыг буулгах арга хэмжээг авах зардал
- Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн 34.5-д Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродром орчмын зэрлэг амьтан, шувууны аюулын судалгааг 3 жил тутам хийх ба тогтоогдсон эрсдэлийг арилгах зардал

Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь нисэхийн аюулгүй байдлыг хангах, аюул осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нисэхийн үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай олон улсын стандарт дүрэм журмын дагуу явуулах зорилготой зорилготой байдаг.

Хуулийн этгээдэд гарч байгаа нэмэлт зардал нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой гарч буй тул нэмэлт зардал нь харьцангуй хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байна гэж үзлээ.

ДӨРӨВ.ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БУЮУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын чиг үүргийг дараах хэлбэрээр өргөжүүлсэн байна.

Хүснэгт 8

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
1	27 ¹ .2.Нисэхийн цаг уурын үйлчилгээний баримт бичгийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, иргэний нисэхийн ерөнхий газар хамтран батална.”	Иргэний нисэхийн ерөнхий газар нисэхийн цаг уурын баримт бичгийг хамтран батална.	Мэдээлэл цуглуулах	15 мин
			Тоо баримтыг боловсруулах	120 мин
			Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Баримт бичиг баталгаажих	30 мин
Нийт хугацаа				405 мин

Хүснэгт 9

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
2	9.2.6.Монгол Улсыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад төлөөлж, тус байгууллагаас баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх; 9.2.7.олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын, болон агаарын тээврийг хялбаршуулах журмыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;	Олон улсын иргэний нисэхийг байгууллагын бодлого, дүрэм журмыг хэрэгжүүлэх, нисэхийн аюулгүй байдлыг журмыг батлах, хянах	Мэдээлэл цуглуулах	60 мин
			Тоо баримтыг боловсруулах	120 мин
			Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Баримт бичиг баталгаажих	60 мин
			Олон нийтэд танилцуулах	30 мин
			Хэрэгжилтэд хяналт тавих	60 мин
Нийт хугацаа				550 мин

Хүснэгт 10

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
3	10.2.11.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох;	Иргэний нисэхийн ерөнхий газар нь төлбөртэй үйлчилгээний тарифыг батлах	Тоо баримтыг боловсруулах	60 мин
			Тооцоолох	120 мин
			Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Бусадтай хамтран хийх хуралдаан	120 мин

			(зөвлөгөөн)	
			Баримт бичиг баталгаажих	30 мин
	Нийт хугацаа			490 мин

Хүснэгт 11

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
4	<p>9.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Конвенц, энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн бүрэн чадамжтай байна.</p> <p>9.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөртэй байна..</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газар нь хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах үйл ажиллагаа хариуцах, сургалтад суулгах.</p>	Тоо баримтыг боловсруулах	120 мин
			Дотоод хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	30 мин
Нийт хугацаа				390 мин

Хүснэгт 12

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
5	<p>7.1.6.иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангахуйц төсөв санхүү, хүний нөөц, цалин хөлсний хэмжээг Конвенцод нийцүүлж батлах.</p>	<p>Иргэний нисэхийн ерөнхий газар төсөв санхүү, хүний нөөц цалингийн хэмжээг батлах</p>	Санхүү, төсөв, цалингийн тооцоо хийх	120 мин
			Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	120 мин
			Дотоод хуралдаан	120 мин
			Төрийн захиргааны байгууллагад хянуулах	30 мин
			Нөөцийг бүрдүүлэх	60 мин

		Сангийн яам зөвшөөрөл авах	90 мин
		Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	30 мин
		Санхүүгийн тайланд тусгах	60 мин
Нийт хугацаа			600 мин

Хүснэгт 13

№	Хуулиар хүлээсэн үүрэг	Үүргийн мэдээллийн агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа
6	11.5.Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг өөр улсад түрээсээр ашиглуулахад дарга тухайн агаарын хөлгийг ашиглах агаарын тээвэрлэгчийн харьяалах улстай Конвенцын 83 bis дугаар зүйлийн дагуу Конвенцын 12, 30, 31 болон 32(а) зүйлд заасан үүрэг, хариуцлага шилжүүлэх гэрээ байгуулна.	Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга нь агаарын хөлгийг ашиглах гэж буй харьяалах улстай Конвенцын зүйлд заасан үүрэг, хариуцлага шилжүүлэх гэрээ байгуулах	Монгол улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслүүлэх саналын дагуу мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	120 мин
			Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөгөөн)	120 мин
			Гэрээний төсөл бэлтгэх	120 мин
			Гэрээ баталгаажуулах	30 мин
			Гэрээг бүртгэх	60 мин
Нийт хугацаа				450 мин

Төрийн байгууллага нь нийт 2885 минутыг дээр дурдсан үүрэгт зарцуулахаар байна. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан төрийн байгууллагын хүлээх үүргийн дагуу төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоог тооцоход давтамжийг дараах байдлаар гаргав. Иргэний нисэхийн байгууллага нь дээрх үүргийг хэрэгжүүлэх тул тохиолдлын тоо нь 1 гэж үзэв.

Хүснэгт 14

д/д	Гүйцэтгэх үүрэг	Зарцуулах хугацаа	Ажлын хөлс	Нэг бүрийн зардал
1	Дээр дурдсан 6 үүрэг	2885 мин	295 төгрөг	851,075 төгрөг

Хэдийгээр хуулийн төсөлд төрийн байгууллагын чиг үүргийг өргөжүүлсэн боловч энэ нь бодит байдалд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах, найдвартай аюулгүй нислэгийн үйлчилгээг бий болгох зохицуулалттай тул үүнтэй холбоотойгоор гарах зардал боломжит хэмжээнд байна.

Хүснэгт 15

д/д	Гүйцэтгэх үүрэг	Нэг бүрийн зардал	Тоон үзүүлэлт	Нийт зардал
1	39.1.1.хяналтын байцаагчийн цалинг иргэний нисэхийн салбарын адилтгах бусад албан тушаалын цалингаас багагүйгээр тогтоох бөгөөд хяналтын байцаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор хяналтын байцаагчаар ажилласан хугацааны нэмэгдэл урамшуулал олгоно;	53,517,300	12 сар	642,207,600
Нийт				642,207,600

Цалингийн нэмэгдлийг 20%-иар, үүнийг дагасан ажилласан хугацааны нэмэгдлийг 10%-иар тооцсон бөгөөд амь нас, эрүүл мэндийн даатгал нь одоо хэрэгжиж буй ажилбар тул нэмэлт зардал гарахгүй. Цалингийн зардлын өсөлт 642,207,600 төгрөг байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 14.8 дугаар зүйлд Иргэний нисэхийн тухай хууль зөрчих 6 төрлийн зөрчлийг дурдсан байсан бол Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой нийт 44 төрлийн зөрчлийг буюу нийтдээ хувь хүн дээр 95,105 нэгжээр, хуулийн этгээдийг 375,000 нэгжээр торгох зохицуулалтыг нэмсэн байна. Нийтдээ 475 мянган нэгж буюу 475 сая төгрөгийн торгуулийн орлого нэмэгдэх зохицуулалтыг тусгасан байна.

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар жил бүр 3 тэрбум төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлж 5-7 тэрбум төгрөгийн төсвийн зардлыг хэмнэх боломжтой байна.

Хүснэгт 16

№	Үзүүлэлт	Улсын төсвөөс хасагдах орлого (сая.төг)
---	----------	---

1	Төсвийн тухай хуулийн дагуу төсөвт төвлөрүүлсэн орлогын буурах дүн (хуулийн 29.1 заалт)	2022	2023	2024	2025	2026
		16,000	5,000	80,000	80,000	40,000

Мөн хуулийн төслийн 29.1-д зааснаар Конвенцын заалтын дагуу агаарын навигацийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэхийг хориглоно. Ингэснээр улсын төсөвт төвлөрүүлэх орлого жилд 40 тэрбум төгрөгөөр буурна. Нөгөө талдаа агаарын навигацийн хураамжийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхгүйгээр нисэхийн аюулгүй байдлыг хангахад зарцуулснаар Монгол Улс Конвенцын дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ найдвартай, бүрэн биелүүлэх боломж бүрдэх юм.

Тус хуулийн өөрчлөлттэй холбоотой Зөрчлийн тухай хуулийн 14.8-д Иргэний нисэхийн тухай хууль зөрчих зүйлд 6 төрлийн зөрчлийг дурдсан байсан бол Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой нийт 44 төрлийн зөрчлийг буюу нийтдээ хувь хүн дээр 95,105 нэгжээр, хуулийн этгээд 375,000 нэгжээр торгох зохицуулалтыг нэмсэн байна. Нийтдээ 475 мянган нэгж буюу 475 сая төгрөгийн торгуулийн орлого нэмэгдэх зохицуулалтыг тусгасан байна.

ТАВ.ДҮГНЭЛТ

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан гарах зардлын тооцоог Засгийн газрын 2015 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийв.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийсэн урьдчилсан шатны үзлэг, шалгалтаар салбарын эрх зүйн орчныг сайжруулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэхийн зэрэгцээ иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын оновчтой, бие даасан, хараат бус санхүүгийн чадавх бүхий тогтолцоог бүрдүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бэлдэх, сургах, дадлагажуулах шаардлагатайг зөвлөж, одоо дүгнэгдэж байгаачлан бага үнэлгээ авах, эсхүл ноцтой аюулгүй байдлын асуудалтай гэж тодорхойлогдвол Монгол Улсын агаарын тээврийн салбар өндөр хэмжээний алдагдалд орж, буцааж нөхөхөд 10 хүртэлх жилийн хугацаа зарцуулахыг анхааруулсан байна.

Дээрх нөхцөл шаардлагыг хангах зорилгоор хуулийн төсөлд Иргэний нисэхийн ерөнхий газрын хараат бус, бие даасан байдлыг хангах, санхүүгийн эх үүсвэр, агаарын навигацийн хураамжийн тодорхой хувиас санхүүжүүлэх нь Монгол улс олон улсын өмнө Конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэх, тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, давтан сургах, салбарын бусад адилтгах албан тушаалын цалин олгох зэрэг санхүүгийн бүрэн чадамжтай байхад чиглэгдсэн байна. Энэхүү үйл ажиллагаа нь улсын төсөвт нөлөөлөл үзүүлэхээргүй байна.

Харин Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт батлагдсан, хэрэгжсэнээр жил бүр 5-7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүжүүлэх зорилгоор олгож байсан зардлыг хэмнэх боломжтой байна.

Мөн хуулийн төслийн 29.1-д зааснаар Конвенцын заалтын дагуу агаарын навигацийн хураамжийг улсын төсөвт төвлөрүүлэхийг хориглосноор улсын төсөвт төвлөрүүлэх орлого жилд 40 тэрбум төгрөгөөр буурна. Ингэснээр Монгол Улс Конвенцын дагуу олон улсын өмнө хүлээсэн агаарын навигацийн хураамжийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхгүйгээр нисэхийн аюулгүй байдлыг хангахад зарцуулах үүргээ найдвартай, бүрэн биелүүлэх боломж бүрдэх юм.

Иргэний нисэхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлэх болон хяналт шалгалтыг нэмэгдүүлэх зорилгыг агуулж буй нь цаашид Монгол Улсын иргэний агаарын тээврийн аюулгүй, найдвартай үйлчилгээг хөгжүүлэх чухал суурь болж байна.

Хуулийн төслийн хүрээнд холбогдох хуулийн этгээдүүдэд гарах зардлыг өртөг тооцох аргачлалын дагуу тооцоолсон бөгөөд зардал, ачаалал нь хэвийн гэж үзсэн болно.

---oOo---

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл (цаашид “хуулийн төсөл” гэх)-ийн зохицуулалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төрлөөр боловсруулагдсан болно.

Хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөг үнэлэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль¹, Хуулийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлал² (цаашид “аргачлал” гэх)-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ:

- 1.1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 1.2.Хуулийн төслөөс үр нөлөө үнэлэх хэсгийг тогтоох;
- 1.3.Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 1.4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтээс дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал
- 2.Ойлгомжтой байдал
- 3.Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх (бүрэн илэрхийлж чадсан эсэх)-ийг тодорхойлох зорилгоор сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль

¹ Хууль тогтоомжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан.

тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах зорилгоор сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн дотооддоо болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах үүднээс хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцсэн эсэх, давхардал, хийдэл, зөрчил байгаа эсэхийг тогтоох зорилгоор аргачлалд заасан асуултад хариулах замаар шалгахаар сонгов.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх (бүрэн илэрхийлж чадсан эсэх)-ийг тодорхойлох зорилгоор хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.9, 8.1.14 дэх заалт, 9-10 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.2-12.5 дахь хэсэг, 15¹, 15² дугаар зүйл, 21, 23, 27¹, 38, 39¹ дүгээр зүйлийг сонгов.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт, түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар сонгов.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хуулийн төслийг бусад хуультай нийцсэн, уялдсан эсэхийг шалгах тул хуулийн төслийг бүхэлд нь шалгахаар сонголоо.

ДӨРӨВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аргачлалд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр нөлөөг үнэлэх хэсгийг дээрх 2 үе шатанд тус тус тогтоосны дагуу тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар тодорхойллоо.

Хүснэгт 1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
-----	------------------	------------------------	-------------------------

1	Зорилгод хүрэх байдал	эрх бүхий этгээдүүдийн бүрэн эрхийн зохицуулалтууд дүрэм журам батлах, боловсруулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт цаг уурын үйлчилгээ хүрээлэн буй орчныг хамгаалах зохицуулалт бүртгэлтэй холбоотой зохицуулалт	Зорилгод дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн сонгосон зохицуулалтууд нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго, хуулиар, хуулийн төслөөр тавьсан зорилгод чиглэгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2.	Ойлгомжтой байдал	хуулийн төсөл бүхэлдээ	Ойлгомжтой байдлыг шалгах: Хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс уг төсөл нь ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах, түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хуулийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгана.
3.	Харилцан уялдаа	хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог дээрх аргачлалын 4.10-т заасан шалгах асуултад хариулах замаар шалгаж дүгнэлт гаргана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, төслийн зохицуулалт нь үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод чиглэсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

Агаарын тээврийн салбар нь олон улсад өрсөлдөх чадварыг тогтмол нэмэгдүүлэх, аюулгүй байдлын хяналтыг олон улсын түвшинд тогтмол хянаж байх, тухайн улс үндэсний хууль тогтоомжоо Олон улсын иргэний нисэхийн байгууллагын загвар хуульд нийцүүлэн тасралтгүй боловсронгуй болгож байх шаардлагатай онцлог салбар юм.

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO) нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналтын олон улсын Байнгын хяналтын аргачлал (USOAP CMA)-ын хүрээнд гишүүн улс орнуудад аудит шалгалт зохион байгуулдаг. Монгол Улс 1989

онд Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцод нэгдэн орж, ICAO-ын гишүүн улс болсноор иргэний нисэхийн бүрэн болон хэсэгчилсэн аудит шалгалтад 5 удаа хамрагдаж байсан бөгөөд 2026 оны 4 дүгээр сард Монгол Улсын агаарын тээврийн зах зээлийн өрсөлдөх чадварт шууд нөлөөлөх бүрэн хэмжээний аудит шалгалтад дахин хамрагдахаар тогтсон.

Дээрх аудит шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 9 дүгээр сард ICAO-ын Ази, Номхон далайн бүсийн төвтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission) Монгол Улсад урьдчилсан аудитын үнэлгээ хийж, залруулах шаардлагатай дараах зөвлөмж өгснөөс дурдвал:

- Иргэний нисэхийн ерөнхий газрын статусыг бие даасан, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байлгах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх;
- албадан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, албадлагын арга хэмжээг ямар байгууллага, ямар албан тушаалтан хариуцахыг тодорхой болгох;
- Хувь хүн, хуулийн этгээдэд хяналтын тодорхой чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх, итгэмжлэх (тухайлбал, нисэхийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн чадавхыг үнэлэх эрх) талаар заах;
- Нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын эрх, үүргийг шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тусгах;
- Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвартай холбоотой зүйл, заалтуудыг хуульд бүрэн тусгах;
- Хүрээлэн буй орчны хамгаалалтын асуудлыг хуульд тусгах;
- ИНЕГ-ын даргын үндсэн чиг үүрэг, эрхийн асуудлыг ICAO-ын дүрэмд нийцүүлэн шинэчлэх, дарга нь иргэний нисэхийн дүрэм батлах бүрэн эрхтэй байх нь нисэхийн аюулгүй байдлыг хангахад цаг хугацааны ач холбогдолтой;
- урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй болгохын тулд зөрчил шалган шийдвэрлэх болон тухайн зөрчлийн шинж чанараас хамаарч авах арга хэмжээг тодорхой тусгах;
- Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ, зөвшөөрөл, батламж, эрх олголт буюу иргэний нисэхийн холбогдох баримт бичгийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох хязгаарлалт тогтоох зэрэг ялгаатай зохицуулалтуудыг тодорхой тусгах;
- ИНЕГ-ын даргаас хяналтын байцаагчдад шилжих эрх мэдлийн зохицуулалт тодорхойгүй байна. Иргэний нисэхийн хяналтын байцаагчдад хяналт шалгалт, аудит, үзлэг шалгалт зэрэг үйл ажиллагаа явуулах эрх олгох;
- Хуулиар зохицуулах (Binding) болон хуулиар зохицуулахгүй (Non-Binding) зохицуулалтын хүрээнд гардаг тушаал, албан даалгавар, албан бичиг, зааварчилгаа, аюулгүй байдал/хамгаалалтын зөвлөмж, хэвлэл, товхимол зэрэг баримт бичгүүдийн статусыг тодорхой болгох;
- Хяналт шалгалт болон албадлагын арга хэмжээний зохицуулалт (PQ 1.051) Монгол Улсад иргэний нисэхийн салбарыг зохицуулах зорилгоор CE-5 түвшинд албадлагын арга хэмжээ авах зохицуулалт бий. Монгол Улсын зөрчлийн тухай хуулийн нисэхийн салбарт хэрэглэх агуулга тодорхой бус

байна. Иргэний нисэхийн тухай хуульд албадлагын арга хэмжээ болон түүнийг хэрхэн хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгах;

- Нисэхийн баримт бичиг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон хязгаарлалт тогтоох эрхийн зохицуулалт (PQ 1.053, 1.055, 1.109, 1.111) Иргэний нисэхийн тухай хуульд үнэмлэх, гэрчилгээ (жишээлбэл: нисгэгч, нислэгийн хөдөлгөөний удирдагчийн үнэмлэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, бүртгэлийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, радио станцын зөвшөөрөл, аэродром, нисэх буудлын гэрчилгээ, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл гэх мэт) олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эсвэл зөрчил гарсан тохиолдолд тэдгээрийн хүчинтэй хугацаанд хязгаарлалт тогтоох эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Мөн агаарын хөлгийг саатуулах, эсхүл үнэмлэх, гэрчилгээг цуцлах эрхийг олгох зохицуулалтыг хуульд тусгаж, холбогдох дүрэм, журамд нарийвчлан тусгах;
- Иргэний нисэхийн хяналтын байцаагчдад хязгаарлалтгүй нэвтрэх эрх олгох, чиг үүргийн дагуу нисэхийн холбогдох баримт бичгүүдэд (жишээлбэл: гарын авлага, гэрчилгээ, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, журам, техникийн баримт бичиг, ажилтны хувийн хэрэг, ажилтны үнэмлэх гэх мэт) хандаж үзлэг хийх эрх олгох зохицуулалтыг тусгах;
- Агаарын хөлөгт авч явах ёстой баримт бичгүүдийн тухай зохицуулалтыг тусгах;
- Өөрийн бүтэц зохион байгуулалтаас гадуурх хувь хүн, хуулийн этгээдэд хяналтын тодорхой чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх, итгэмжлэх (тухайлбал нисэхийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн чадавхыг үнэлэх эрх), томилох эрхтэй байхыг хуульд тодорхой заах.

Монгол Улсын Их Хурлаас Иргэний нисэхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ыг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна. Тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1. дэх хэсэгт “Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан нь зөвхөн зохицуулах харилцааг дурдах агуулгатай, зорилтын шинжтэй байна. Харин хуулийн төсөлд зорилгыг илүү хүрэх үр дүнд чиглүүлж “нисэхийн аюулгүй байдлыг хангах, Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангах” агуулгаар тодорхойлжээ.

Иймд хуулийн төслийн тандан судалгааны тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгасан байдлаас харахад хуулийн төслийн зорилгыг Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангах замаар иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, агаарын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэж тодорхойлж болохоор байна.

Хүснэгт 2

Хуулийн төслийн зорилго	Хуулийн төслийн зохицуулалт
-------------------------	-----------------------------

<p>Үзэл баримтлалаар тодорхойлсон зорилго:</p> <p>иргэний нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх</p> <p>Энэ хуулийн төслийн зорилго:</p> <p>Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<ul style="list-style-type: none"> - эрх бүхий этгээдүүдийн бүрэн эрхийн зохицуулалтууд - дүрэм журам батлах, боловсруулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт - цаг уурын үйлчилгээ - хүрээлэн буй орчныг хамгаалах зохицуулалт - бүртгэлтэй холбоотой зохицуулалт
--	--

Хүснэгт 3

<p style="text-align: center;">5¹15¹, 15² дугаар зүйл:</p> <p style="text-align: center;">“15¹ дугаар зүйл. Хүрээлэн буй орчны хамгаалалт</p> <p>15¹.1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь Конвенцын Хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.</p> <p>15¹.2.Энэ хуулийн 15.1-т заасныг хангасан агаарын хөлгийн хөдөлгүүрийн дуу чимээний гэрчилгээг Дарга олгоно.</p>

Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission)-ийн хийсэн урьдчилсан аудитын үнэлгээгээр Чикагогийн конвенцын Хавсралт 16-д заасан Хүрээлэн буй орчны хамгаалалтын асуудлыг хуульд тусгах зөвлөмжийг тусгайлан өгсөн³.

Хуулийн төслийн дээрх заалт нь хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх замаар манай улсын агаарын тээврийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгыг хангахад чиглэсэн байна гэж үзлээ. Түүнчлэн хуулийн төслийн 38.1.3 дахь заалтад “хүрээлэн буй орчинд илтэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд Даргын тогтоосон журмын дагуу хяналтын байцаагч агаарын хөлгийг саатуулах” зохицуулалтыг шинээр бий болгож байгаа нь хуулийн төслийг зорилгыг дэмжсэн зохицуулалтын нэг хэсэг байна гэж үзлээ.

Харин хуулийн төсөлд хүрээлэн байгаа орчныг хамгаалах, түүнд нөлөө үзүүлэх зарим зохицуулалтыг (дуу чимээ, агаарын бохирдол) дэлгэрүүлэн тусгах нь хууль батлагдсаны дараа хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

³С/В. ICAO APAC CAT mission report CE-1/ Хуулийн төслийн тандан судалгааны тайлан 2026 он.

12/27¹ дүгээр зүйл:**“27¹ дүгээр зүйл.Нисэхийн цаг уурын үйлчилгээ**

27¹.1.Нисэхийн цаг уурын үйлчилгээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа Иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн нэгж үзүүлнэ.

27¹.2.Нисэхийн цаг уурын үйлчилгээний баримт бичгийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Иргэний нисэхийн ерөнхий газар хамтран батална.”

Иргэний нисэхийн тухай хуулийн Агаарын навигацийн үйлчилгээ бүлэгт цаг уурын үйлчилгээг үзүүлэх этгээд, энэ талаар батлах нарийвчилсан журмын талаар тусгасан нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, Иргэний нисэхийн дүрэм, хуулиар тусгайлан эрх олгож батлах дээрх баримт бичгийн дагуу нарийвчлан зохицуулах боломжтойгоос гадна хуульд өөрт нь ерөнхий агуулга, суурь зохицуулалтыг тусгасан нь оновчтой байна.

3/12 дугаар зүйлийн 12.2-12.5 дахь хэсэг:

“12.2.Иргэний нисэхийн дүрэмд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинээр дүрэм гаргана:

12.2.1.Конвенцын Хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүр боломжит хугацаанд;

12.2.2.агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай нь тогтоогдсон;

12.2.3.иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор нэмэлт зохицуулалт хийх зайлшгүй нөхцөл үүссэн.

12.3.Иргэний нисэхийн дүрмийг шинэчлэн батлах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн дүрмийн дагуу эрх, үүрэг үүссэн этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгаж болно.

12.4.Нислэгийн аюулгүй байдалд хамаарах онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд шуурхай дүрэм, шилжилтийн цаг үеийн асуудлыг зохицуулах зорилгоор тусгай дүрэм гаргаж болно.

8/21¹ дүгээр зүйл.Агаарын хөлөгт авч явах баримт бичиг**39¹ дүгээр зүйл.Иргэний нисэхийн баримт бичиг олгох,
түдгэлзүүлэх, хүчингүй болгох****2/8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт:**

8.1.9.Иргэний нисэхийн ерөнхий газар, агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллагын бүтцийг батлах;

Тайлбар: Энэ хуулийн “агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах байгууллага” гэснийг Конвенцын 13 дугаар хавсралтад заасан агаарын хөлгийн осол, инцидентыг шинжлэх шалгах алба гэж ойлгож хэрэглэнэ.

11 дүгээр зүйл.Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгох

Хуулийн төсөлд Иргэний нисэхийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэн батлах тохиолдлыг тусгасан, агаарын хөлөгт авч явах баримт бичгүүдийг тусгайлан дурдсан, нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгохтой холбоотой зохицуулалт шинээр бий болгохоор тусгасан нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэгджээ.

Хүснэгт 6

3/9-11 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Иргэний нисэхийн ерөнхий газар, чиг үүрэг, бүрэн эрхийн баталгаа

9.1.Монгол Улсад иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтын тогтолцоог Конвенцын стандарт, зөвлөмжид нийцүүлэн бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, мэргэжлийн байгууллага нь иргэний нисэхийн ерөнхий газар байна.

9.2.Иргэний нисэхийн ерөнхий газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь хуулийн этгээд мөн бөгөөд түүний дүрмийг иргэний нисэхийн ерөнхий газрын саналыг үндэслэн Сайд батална. Иргэний нисэхийн ерөнхий газар Конвенц, энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн бүрэн чадамжтай байна.

9.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалт, аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөртэй байх бөгөөд салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах үйл ажиллагааг иргэний нисэхийн ерөнхий газар өөрөө хариуцна. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Сайдын баталсан орон тооны дээд хязгаарт багтаан чиг үүргийн зохион байгуулалт хийнэ.

9.5.Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг тасралтгүй хангуулах санхүүгийн нөөцтэй байх бөгөөд агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг иргэний нисэхийн ерөнхий газрын аюулгүйн нөөцийн санд төвлөрүүлэн Сайдын зөвшөөрлөөр захиран зарцуулна. Шаардлагатай гэж үзвэл сан бүрдүүлэх, зарцуулахтай холбоотой журмыг Сайдын зөвшөөрлөөр иргэний нисэхийн ерөнхий газрын дарга батална. Иргэний нисэхийн ерөнхий газар санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, цахим хуудаастаа ил тод нийтэлнэ.

10 дугаар зүйл.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, түүний бүрэн эрх

10.2.15.хуульд заасан бусад.

“38 дугаар зүйл.Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх

Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission)-ийн 2025 оны 9 дүгээр сард Монгол Улсад хийсэн урьдчилсан аудитын үнэлгээний тайланд Иргэний нисэхийн ерөнхий

газрын статусыг бие даасан, хөндлөнгийн нөлөөнөөс ангид байлгах, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалттай санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай байх шаардлагатай талаар дүгнэжээ. Уг асуудлыг иргэний нисэхийн үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм, журмыг шуурхай батлах, зарим тодорхой асуудлаа бие даан шийдвэрлэх, санхүүжилтийн хувьд тогтвортой байхад чиглэсэн зохицуулалт тусгасан нь зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалт байна.

Үндэсний аудитын газрын 2025 оны дүгнэлт, зөвлөмжид⁴ Иргэний нисэхийн ерөнхий газрын хуулийн этгээдийн баталсан хэлбэр, бүтцээр нь ажиллуулах шаардлагатай талаар зөвлөснийг хэрэгжүүлэхээр хуулийн төслийн 9.1 дэх заалтад буюу Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагын өмнө хариуцлага хүлээж хараат бус бие даасан байдлаар энэ хуулийн 9.6-д заасан орлогоор санхүүжин үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна гэж тодорхойлсон нь мөн зорилгод чиглэгджээ.

Харин хуулийн төсөлд төрийн захиргааны байгууллагыг “Иргэний нисэхийн ерөнхий газар” гэж, төрийн захиргааны төв байгууллагыг “яам” гэж, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг “сайд” гэж тус тус өөрчлөх нь нисэхийн аюулгүй байдлыг хангах, иргэний нисэхийг бие даасан байдлыг хангах хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод чиглэсэн зохицуулалт гэж үзэх боломжгүй бөгөөд үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбоог хангахад хүндрэл учрахаар байгаад анхаарч, уг асуудлыг холбогдох эрх бүхий этгээдэд тайлбарлах замаар шийдвэрлэх боломжтой үзэж байна.

Түүнчлэн 2023 онд Улсын Их Хурлаас баталсан Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд олон улсын гэрээний дагуу иргэний нисэх байгууллагын бие даасан байдлыг хангах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгжүүлэгч агентлагийн статусыг өөрчилж, тохируулагч агентлаг болгох шаардлагатай гэж дүгнэсний дагуу Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулсан зохицуулалт хэрэгжиж эхлээд 1 жил гаруй болж байгааг анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нийт 32 хэрэгжүүлэгч агентлаг, 8 тохируулагч агентлаг ажиллаж байна.⁵

3.2. “Ойлгомжтой байдлыг шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгаж тогтоохыг зорилоо.

⁴ Гүйцэтгэлийн аудитын тайлан /Иргэний нисэхийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө 2025 он/ Үндэсний аудитын газар

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1>

Хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг аргачлалын дагуу дараах асуултад хариулт өгөх байдлаар шалгалаа.

Хүснэгт 7

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
<i>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</i>	<i>Шаардлага хангасан эсэх</i>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: “17/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”; 18/улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно. гэж заасан болон олон улсын гэрээ, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт “Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.” буюу хуулиар олгогдсон эрхийг бусдад шилжүүлэхгүй зохицуулалттай. Иймд хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасан эрх шилжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсруулахдаа шилжүүлж болох эрхийг хуульд өөрт нь эш татах байдлаар тодорхой тусгаж шийдвэрлэх боломжтой.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төслийн 12.3 дахь хэсэг шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгайлан дурдсан байна. Энэ хэсгийг хуулийн төсөлд тусгах шаардлагагүй бөгөөд иргэний нисэхийн дүрэмд, эсхүл тухайн шийдвэр гаргасан захиргааны актадаа тусган хэрэгжүүлэх боломжтой. Энэ талаар Захиргааны ерөнхий хуулийн итгэл хамгаалах зарчмыг захиргааны байгууллага баримтлах зохицуулалт үйлчилж байгаа болно.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	шаардлагад нийцсэн.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Хуулийн төслийн заалт нь хуулийн заалттай зөрчилдөөгүй байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Хуулийн төслийн 3.2 дахь хэсэгт “Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийн агаарын орон зайд төгс, онцгой бүрэн эрхтэй.” гэж тусгасан нь тунхагласан шинжтэй гэж үзэхээр байна.

<p>29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;</p>	<p>1/Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т “Хуульд заасан бусад хуулиас эшлэл хийхдээ тухайн заалтын эх бичвэрээр нь хуулбарлахыг хориглоно” гэж заасныг баримтлан Хуулийн төслийн 5 дугаар зүйл буюу хуулийн нэр томъёоны тодорхойлолтод “Монгол Улсын хилийн тухай⁶ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг” /төслийн 5.1.22-т/ гэж, мөн “аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” /төслийн 26.6-д/ гэснийг Улсын нисэхийн тухай хуулиас эшлэлийг тус тус зөв хэрэглэсэн байна.</p> <p>2/Уг боловсруулж байгаа хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэртэй тул хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх шаардлагагүй. Тодруулбал, анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөлд хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд тусгадгийг анхаарах.</p>
<p>29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Тусгасан.</p>
<p>29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Иргэний нисэхийн дүрэм, эсхүл тухайн шийдвэр гаргасан захиргааны актад тусган хэрэгжүүлэх боломжтой тул хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.</p>
<p>29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Хуулийн төсөлтэй хамт Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэсэн 6 хуулийн төслийг боловсруулсан.</p>
<p>29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.</p>	<p>Хуулийн төсөл нь нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тул хуулийн зорилго гэсэн зүйлгүй боловч тус хуулийн зорилгыг төсөлд “Энэ хуулийн зорилго нь иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангуулахад чиглэсэн харилцааг зохицуулах, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенц /цаашид “конвенц” гэх/ болон Монгол Улс нэгдэн орсон бусад конвенцоор хүлээсэн үүргийн</p>

⁶Монгол Улсын хилийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

	биелэлтийг хангахад оршино” гэж өөрчлөн найруулахаар тусгажээ.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Хуулийн төслийн 5.1.22-т “Монгол Улсын нутаг дэвсгэр” гэсэн нэр томъёо хэрэглэсэн.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	шаардлагад нийцсэн.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.5.1-д “уг нэр томъёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол” гадаад нэр томъёог хэрэглэж болно гэж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд “монгол хэлэнд тохирох үг байгаа тохиолдолд гадаад хэлний нэр томъёо хэрэглэхгүй” гэж тус тус заасан. Гэтэл хуулийн төслийн 3.2-т “маневр” гэсэн гадаад үгийг хуулийн төсөлд тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх заалтыг зөрчсөн байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хууль, холбогдох аргачлалын дагуу уг “маневр” гэсэн үгийг монгол хэлэнд тохирох үгийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	шаардлагад нийцсэн.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	шаардлагад нийцсэн.

3.3. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорилоо.

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг эрмэлзсэн.

д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	“Хууль тогтоомж” гэсэн хэсэгт Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг тусгасан байгаа нь оновчтой биш, шаардлагагүй тул хасах.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөлд “Зөрчил” “осол”, “ноцтой зөрчил”, “инцидент тохиолдол” гэсэн нэр томъёог тусгайлан анхаарч зааг ялгааг гаргаж шинээр тодорхойлох шаардлагатай. Тухайлбал “зөрчил” гэдгийг Зөрчлийн тухай хуульд тусгайлан тодорхойлж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд Зөрчлийн тухай

		хуульд заасан үйлдлүүдийг шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлдэг болохыг анхаарах.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	<p>Захиргааны ерөнхий хуулийн зарим зохицуулалт тухайлбал, яам, Иргэний нисэхийн ерөнхий газар зэрэг нэрийг хэрэглэхээр тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцэхгүй болно.</p> <p>Хуулийн төслийн 9.3-т иргэний нисэхийн ерөнхий газрын хуулийн этгээд хэлбэрээр байгуулах, дүрмийг сайд батлах агуулгаар тусгажээ. Хэрэв төрийн өмчит хуулийн этгээд хэлбэрээр зохион байгуулах бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үйлчлэлд хамаарна. Тус хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Засгийн газар хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах зохицуулалттай. Шаардлагатай бол дагалдах хуулийн төслийг боловсруулах.</p>
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан. Иргэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.” гэж заасан. Иймд хуулийн төслийн зорилгыг Чикагогийн конвенц, Монгол Улсын нэгдэн орсон бусад конвенцоор хүлээх үүргийг биелүүлэх гэж өөрчлөн найруулсан хэсгийг дахин нягтлах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын олон улсын гэрээг дагаж мөрдөх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх талаар Үндсэн хууль болон бусад хуулиар нэгэнт зохицуулсан тул энэ агуулгыг давхардуулан хуульчлах шаардлагагүй болно.</p> <p>Хуулийн төслийн 3.2-т “... Монгол Улсын агаарын орон зайд нислэг үйлдэх, маневр хийх аливаа агаарын хөлөг нь иргэний нисэхийн дүрэм, холбогдох журмыг дагаж мөрдөнө.” гэжээ. Төсөлд тусгасан уг асуудал нь Иргэний нисэхийн тухай хуулийн 2.1 хэсэгт заасан “Иргэний нисэхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.” гэж заасантай хамаарч байгааг анхаарах.</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан байцаагчийн шалган шийдвэрлэх зөрчил, энэ хуульд заасан зөрчилтэй давхардах, ойлгомжгүй байдал үүсэх магадлалтай.</p>
6	хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хэрэгжүүлэх этгээд тодорхой болно. Хуулийн төсөл яам, агентлаг, Төрийн тусгай хамгаалалтын газар, Ус цаг уур орчныг шинжилгээний газар, Онцгой

		байдлын ерөнхий газар зэрэг байгууллагад үүрэг хүлээлгэж байна.
7	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төслийн 14.1-д өмчлөлтэй холбоотой мэдээллийг хэнд, ямар зорилгоор гаргах нь тодорхойгүй байгааг анхаарах.
8	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төслийн 9.2.1-д сайдын батлах дүрэм, журмыг боловсруулах, батлуулах, бүртгүүлэх үүргийг агентлагийн даргад хүлээлгэхээр тусгажээ. Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актыг баталсан этгээд нь хариуцан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Иймд агентлагийн даргыг зөвхөн боловсруулах, хэрэгжүүлэх гэсэн агуулгаар өөрчлөн тусгах шаардлагатай.
9	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Зөвлөмжид “Хувь хүн, хуулийн этгээдэд хяналтын тодорхой чиг үүрэг, хариуцлагыг шилжүүлэх, итгэмжлэх (тухайлбал нисэхийн мэргэжилтнүүдийн сэтгэцийн чадавхыг үнэлэх эрх)” гэж зөвлөсөн боловч энэ талаар хуулийн төсөлд тусгаагүй.
10	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвартай холбоотой тусгайлсан зохицуулалт байхгүй.
11	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөх шаардлагагүй болно.
12	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой ямар нэг зохицуулалт байхгүй бөгөөд гэрээ байгуулахтай холбоотойгоор үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хууль, гэрээнд заасны дагуу шийдвэрлэх боломжтой гэж үзсэн байна.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төслийн 18.2-т гадаадын агаарын тээвэрлэгч Монгол Улсын нутаг дэвсгэр орон нутгийн тогтмол нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор тусгажээ. Энэ нь зорилгод хамааралгүй, үзэл баримтлалд тусгагдаагүй, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн, хөрөнгө оруулалтыг хязгаарласан зохицуулалт байна.
14	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Зорчигчийн мэдээллийг холбогдох этгээдэд өгч болохоор тусгасан нь хүний эрхийг хязгаарлахад чиглэсэн зохицуулалт мөн.
15	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хувь хүний мэргэжлийн, эрүүл мэндийн гэрчилгээжүүлэлт, маягт хүлээн зөвшөөрөх үүргийг иргэний нисэхийн ерөнхий газрын даргын бүрэн эрхэд нэмж олгож байгаа нь ийм эрсдэл бий болгож болно.
16	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулна. Түүнчлэн албадлагын арга хэмжээний талаар нэмэлт зохицуулалт тусгасан.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт (зүйл, хэсэг, заалт)-д тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож,

давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зохицуулалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад зөвлөмж өгөх зорилгоор хийлээ.

Хуулийн төслийн тандан судалгааны тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөлд тусгасан байдлаас харахад хуулийн төслийн зорилгыг Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангах замаар иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, агаарын тээврийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх гэж тодорхойлж болохоор байна.

Ийнхүү зорилгыг хангахад чиглэсэн зохицуулалт буюу эрх бүхий этгээдүүдийн бүрэн эрхийн зохицуулалтууд, дүрэм журам батлах, боловсруулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, цаг уурын үйлчилгээ, хүрээлэн буй орчныг хамгаалах зохицуулалт, иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын зарим тодорхой бүрэн эрхийг өгөхөөр тусгасан, бүртгэл, гэрчилгээжүүлэлтийг боловсронгуй болгох зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Ялангуяа иргэний нисэхийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэчлэн батлах тохиолдлыг, агаарын хөлөгт авч явах шаардлагатай баримт бичгийн зохицуулалт, нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгохтой холбоотой зохицуулалт тусгасан нь үзэл баримтлалаар тодорхойлсон иргэний нисэхийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгод нийцэж байна.

Харин хуулийн төсөлд төрийн захиргааны байгууллагыг “Иргэний нисэхийн ерөнхий газар” гэж, төрийн захиргааны төв байгууллагыг “яам” гэж, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнийг “сайд” гэж тус тус өөрчлөх нь нисэхийн аюулгүй байдлыг хангах, иргэний нисэхийг бие даасан байдлыг хангах хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгод чиглэсэн зохицуулалт гэж үзэх боломжгүй бөгөөд үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбоог хангахад хүндрэл учрахаар байгааг анхаарч, уг асуудлыг холбогдох эрх бүхий этгээдэд тайлбарлах замаар шийдвэрлэх боломжтой үзэж байна.

Улсын Их Хурлаас 2023 онд баталсан Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд олон улсын гэрээний дагуу бие даасан байдлыг хангах зорилгоор Иргэний нисэхийн ерөнхий газрын хэрэгжүүлэгч агентлагийн статусыг өөрчилж тохируулагч агентлаг болгох шаардлагатай гэж дүгнэсний дагуу Улсын Их Хурлын тогтоолд өөрчлөлт оруулсан зохицуулалт хэрэгжиж эхлээд 1 жил гаруй болж байгааг анхаарах хэрэгтэй. Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д нийт 32 хэрэгжүүлэгч агентлаг, 8 тохируулагч агентлаг ажиллаж байна.⁷

Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь аудит шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 9 дүгээр сард Олон

⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141010887611&showType=1>

улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын Ази, Номхон далайн бүсийн төвтэй зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан, Хамтарсан ажиллагааны баг (CAT Mission) Монгол Улсад урьдчилсан аудитын үнэлгээ хийж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд бүхэлдээ чиглэгджээ.

Урьдчилсан шалгалтын тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг бүхэлд нь Иргэний нисэхийн тухай хуульд бус тус хуулиар эрх олгосны дагуу батлах Иргэний нисэхийн дүрэмд тусган хэрэгжүүлэх боломжтой талаар тусгасан байх тул хуулийн төсөл зайлшгүй шаардлагатай суурь зохицуулалтыг тусгах замаар хуулийн төслийн үзэл баримтлалаар тавьсан зорилгыг хангах боломжтойг тусгайлан анхаарах шаардлагатай. Ингэхдээ аливаа этгээдэд бүрэн эрх олгох, үүрэг хариуцлага хүлээлгэх, эсхүл хүн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах, албадлагын арга хэмжээ авахтай холбоотой тохиолдол, бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг хуульд тусгаж, зөвлөмжид өгсөн бусад асуудлыг дүрэмд тусгах замаар шийдвэрлэх нь оновчтой байна.

Захиргааны ерөнхий хуульд аливаа захиргааны байгууллага хуулиар өөрт олгогдсон эрхийг бусдад шилжүүлэхийг хориглох зохицуулалттай. Иймд хуульд захиргааны байгууллага зөвхөн өөрөө хэрэгжүүлэх боломжтой эрхүүдийг хуулийн төсөлд тусгах, шилжүүлэх боломжтой зарим эрхийг дүрэмдээ тусгах боломжтой юм.

Иргэний нисэхийн улсын байцаагчийн эрхийг нэмэгдүүлэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дахь эрх бүхий албан тушаалтны эрхтэй сайтар уялдуулах шаардлагатай. Зөрчлийн тухай хуульд зөрчлийн үйлдэлд тооцохоор заасан л бол Зөрчлийн шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх бүхий албан тушаалтан /байцаагч/ прокурорын хяналтад үйл ажиллагааг гүйцэтгэх зохицуулалттай. Харин Иргэний нисэхийн тухай хуулийн төсөлд заасан байцаагчийн эрх, зарим албадлагын арга хэмжээг Зөрчлийн тухай хууль хамаарахгүйгээр хэрэглэх боломжийг бий болгохын тул зөрчилд тооцох үйлдлээс хасах, одоо байгааг цөөрүүлэх боломжтой.

Ийнхүү зөрчлийн үйлдлийг хасаж байгаа нь аливаа хуулийн хяналтаас гадуур байх ойлголт биш бөгөөд зөрчлийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд шийдвэрлэх, түүнчлэн хэрэв төрийн эрх бүхий албан хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйл буюу Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчилд тооцон шийтгэл хүлээлгэх зохицуулалт үйлчлэх зохицуулалттай.

Түүнчлэн хуулийн төсөлд нэг бүрчлэн тоочсон арга хэмжээ, байршил, баримт бичиг зэрэг байгааг тусгайлан анхаарч, ийнхүү хуульд тоочин тусгах нь дурдагдаагүй зарим нь хуулиас гадуур үлдэх, хангалттай бүрэн зохицуулалт болж чаддаггүй сөрөг үр дагавартайг анхаарах шаардлагатай.

Хуулийн төсөлд нэмсэн, өөрчилсөн нэр томъёог сайтар нягталж, Монгол Улсад нэр томъёог хуулиас доогуур түвшний актаар тодорхойлж болохгүй зохицуулалт үйлчилдэг боловч иргэний нисэхийн онцлог харилцаа, Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх шаардлагаар Иргэний нисэхийн дүрмээр тайлбарлаж болох агуулгыг хуулийн төсөлд нэмж тусгах нь хууль батлагдсаны дараа хуулийн

заалт, хуулиар эрх олгосны дагуу батлан гаргах захиргааны шийдвэрүүд нь иж бүрэн хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Хуулийн төслийн ойлгомжтой байдал, харилцан уялдааны талаар дүгнэлт, зөвлөмжийг тус тусын хэсгээс үзэж хуулийн төслийг боловсронгуй болгох боломжтой.

---oOo---

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Иргэний нисэхийн тухай хууль 2023 он
3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль 1993 он
4. Засгийн газрын агентлагийн тухай хууль
5. Захиргааны ерөнхий хууль
6. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай
7. Хууль тогтоомжийн тухай хууль
8. Зөрчлийн тухай хууль
9. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
10. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
11. Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоол
12. Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоол
13. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал 2023 он
14. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийн тандан судалгааны тайлан
15. Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, төсөл
16. Үндэсний аудитын газрын тайлан

